

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛД **НҮҮР АМНЫ ИХ ЭМЧ** МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН **ЖИШИГ СОРИЛ - I**

Сорилын зөв хариулт

1-A, 2-A, 3-C, 4-E, 5-E, 6-B, 7-A, 8-B, 9-C, 10-A, 11-B, 12-C, 13-D, 14-C, 15-D, 16-B,
17-D, 18-D, 19-C, 20-B, 21-C, 22-A, 23-B, 24-C, 25-A, 26-A, 27-A, 28-B, 29-A, 30-A, 31-
A, 32-A, 33-A, 34-B, 35-B, 36-A, 37-C, 38-B, 39-A, 40-C, 41-C, 42-A, 43-B, 44-B, 45-A,
46-B, 47-D, 48-A, 49-A, 50-B, 51-B, 52-C, 53-C, 54-B, 55-C, 56-D, 57-B, 58-A, 59-B, 60-
A, 61-C, 62-A, 63-C, 64-A, 65-B, 66-B, 67-A, 68-C, 69-B, 70-C, 71-B, 72-A, 73-A, 74-B,
75-C, 76-C, 77-B, 78-D, 79-E, 80-E, 81-D, 82-C, 83-D, 84-B, 85-A, 86-E, 87-A, 88-D, 89-
A, 90-A, 91-A, 92-B, 93-A, 94-A, 95-C, 96-B, 97-B, 98-B, 99-A, 100-D, 101-A, 102-C,
103-D, 104-B, 105-C, 106-C, 107-D, 108-C, 109-B, 110-A, 111-D, 112-D, 113-A, 114-E,
115-C, 116-E, 117-A, 118-A, 119-B, 120-E, 121-A, 122-A, 123-A, 124-B, 125-C, 126-B,
127-B, 128-B, 129-A, 130-B, 131-C, 132-A, 133-B, 134-B, 135-C, 136-B, 137-C, 138-C,
139-C, 140-E, 141-A, 142-C, 143-A, 144-E, 145-A, 146-C, 147-C, 148-D, 149-C, 150-A,
151-B, 152-B, 153-A, 154-B, 155-B, 156-B, 157-C, 158-B, 159-D, 160-C, 161-A, 162-B,
163-C, 164-E, 165-B, 166-C, 167-D, 168-B, 169-C, 170-C, 171-A, 172-C, 173-B, 174-E,
175-B, 176-A, 177-B, 178-B, 179-B, 180-C, 181-C, 182-A, 183-C, 184-E, 185-C, 186-D,
187-D, 188-D, 189-D, 190-D, 191-C, 192-A, 193-A, 194-A, 195-B, 196-C, 197-A, 198-C,
199-B, 200-C, 201-C, 202-A, 203-B, 204-C, 205-B, 206-C, 207-A, 208-B, 209-B, 210-D,
211-A, 212-C, 213-B, 214-E, 215-C, 216-C, 217-A, 218-B, 219-C, 220-A, 221-C, 222-D,
223-A, 224-A, 225-C, 226-A, 227-A, 228-B, 229-A, 230-A, 231-A, 232-D, 233-A, 234-A,
235-A, 236-B, 237-A, 238-D, 239-D, 240-A, 241-D, 242-A, 243-A, 244-A, 245-B, 246-A,
247-B, 248-B, 249-A, 250-D, 251-B, 252-C, 253-C, 254-B, 255-C, 256-A, 257-B, 258-C,
259-A, 260-C, 261-C, 262-A, 263-B, 264-D, 265-D, 266-B, 267-A, 268-B, 269-C, 270-D,
271-A, 272-B, 273-C, 274-B, 275-B, 276-C, 277-D, 278-B, 279-A, 280-D, 281-A, 282-C,
283-C, 284-C, 285-B, 286-A, 287-C, 288-B, 289-D, 290-D, 291-B, 292-B, 293-A, 294-E,
295-B, 296-D, 297-C, 298-C, 299-B, 300-A, 301-C, 302-B, 303-B, 304-C, 305-C, 306-B,
307-B, 308-C, 309-A, 310-A, 311-A, 312-C, 313-D, 314-C, 315-D, 316-D, 317-B, 318-A,
319-B, 320-A, 321-A, 322-D, 323-C, 324-A, 325-C, 326-D, 327-A, 328-A, 329-E, 330-A,
331-A, 332-D, 333-D, 334-A, 335-E, 336-E, 337-D, 338-E, 339-D, 340-C, 341-A, 342-C,
343-D, 344-E, 345-E, 346-D, 347-C, 348-C, 349-E, 350-E, 351-E, 352-E, 353-A, 354-B,
355-C, 356-C, 357-C, 358-D, 359-E, 360-A, 361-E, 362-A, 363-C, 364-D, 365-C, 366-B,
367-C, 368-C, 369-E, 370-B, 371-E, 372-A, 373-C, 374-A, 375-E, 376-A, 377-C, 378-C,
379-A, 380-B, 381-A, 382-C, 383-E, 384-C, 385-B, 386-A, 387-C, 388-C, 389-D, 390-D,
391-D, 392-C, 393-A, 394-B, 395-C, 396-B, 397-D, 398-C, 399-C, 400-B, 401-C, 402-B,
403-B, 404-A, 405-D, 406-A, 407-B, 408-A, 409-A, 410-B, 411-B, 412-B, 413-C, 414-A,
415-A, 416-A, 417-D, 418-D, 419-A, 420-B, 421-A, 422-B, 423-D, 424-E, 425-E, 426-C,
427-C, 428-C, 429-C, 430-E, 431-E, 432-D, 433-D, 434-C, 435-C,

Сорил хариулах заавар:

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

::A01::Бөөрний архаг өвчний 3-р үед ТШХ яаж өөрчлөгдөх вэ?

A. ТШХ бага зэрэг буурсан 60-89 мл/мин

B. ТШХ бага зэрэг буурсан 30-60 мл/мин

C. ТШХ буурсан 30-59 мл/мин

D. ТШХ буурсан 30-49 мл/мин

E. ТШХ маш их буурсан 15-29 мл/мин

{ ~A ~B =C ~D ~E }

Сонгогдсон сорил

/1./ Хоншоор, гурамсан мэдрэлийн аль салаагаар мэдрэлжүүлэгдэх вэ?

A. A. I салаа

B. B. II салаа

C. C. III салаа

D. D. IV салаа

E. E. V салаа

/2./ Сувгийн багажийг дэс дарааллаар нь хэрэглэнэ. Учир нь сувагт тавцан үүсвэл үндсэн сувгаа олж эмчлэхэд төвөгтэй.

/3./ Зөөлцийн цочмог тархмал үрэвслийн үед өвдөлт мэдрэлийн судлыг дагаж өвдөнө. Яагаад гэвэл арьсны мэдрэлийн төгсгөлүүд цочирсон.

/4./ Зөөлцийн архаг үхжилт үрэвслийн үед зөвхөн цөгцөн хэсгийн зөөлц үхжинэ. Иймд кальцийн гидроксид агуулсан эмчилгээний бэлдмэлийг шүдний хөндий нээгдсэн цэгт тавина.

/5./ Зөөлцийн архаг ширхэглэг үрэвслийн үед шөнө хүчтэй өвдөнө. Учир нь зөөлц үхжиж эхэлнэ.

/6./ Холбоосын үрэвслийн аль хэлбэрийн үед тогшилтонд хүчтэй өвдөлт өгөх вэ?

A. холбоосын хурц үрэвслийн хордлогын үе

B. холбоосын хурц үрэвслийн шүүдэст үе

C. холбоосын архаг үрэвсэл

D. холбоосны мөхлөнгөр үрэвсэл

E. холбоосын сорвижилтот үрэвслийн үе

/7./ Холбоосын архаг ширхэглэг үрэвслийн эмчилгээний үед сувгийг ямар түвшинд ломбодох вэ?

A. сурвалжийн сувгийн орой хүртэл

B. сурвалжийн сувгийн оройгоос гартал

C. сурвалжийн сувгийн дунд хэсэг хүртэл

D. сурвалжийн сувгийн доод 1/3 хэсэг хүртэл

E. дээрх хариултуудын аль нь ч биш

/8./ Холбоосын архаг үрэвслийн үед ясны эдэд үүссэн эвдрэл эмчилгээний дараа хэдий хугацаанд төлжих вэ?

A. 1-2 сар

B. 6-9 сар

C. 12-24 сар

D. 9-12 сар

Е. 3-6 сар

/9./ Холбоосын архаг үрэвслийн эмчилгээг сонгохдоо ерөнхий биеийн өвчнийг харгалзаж үзэх үү?

- А. харгалзана
- В. харгалзахгүй
- С. үрэвслийн хэлбэрээс шалтгаална
- Д. өвчний үе шатаас шалтгаална
- Е. шүдний хэлбэрээс шалтгаална

/10./ Шүдний гаралтай халдвар нь ерөнхий биеийн өвчний халдварын голомт болох уу?

- А. болно
- В. болохгүй
- С. үүсгэгчээс шалтгаална
- Д. өвчний явцаас шалтгаална
- Е. тухайн хүний биеийн эсэргүүцлээс шалтгаална

/11./ Задарсан зөөлцийг сувгаас яаж авах вэ?

- А. нэг удаа
- В. хэсэгчлэн
- С. бөөгнөрүүлж байгаад
- Д. таллаж
- Е. агаараар үлээлгэж

/12./ Ямар тохиолдолд холбоосын архаг үрэвслийг нэг удаагийн ирэлтээр эмчлэх вэ?

- А. холбоосын архаг ширхэглэг үрэвсэл
- В. холбоосын хурц үрэвсэл
- С. 1 сурвалжтай шүдний цорго үүссэн архаг мөхлөнгөрших үрэвсэл

- Д. цорго үүссэн архаг мөхлөнгөрт үрэвсэл
- Е. сэдрэлийнх нь үед

/13./ Хүнцэлийн хордлогоос үүссэн холбоосын үрэвслийн үед авах арга хэмжээг дурьдана уу.

- А. хүнцэлийн зуурмаг дахин тавих
- В. зөөлцийг тайрч, хөвөн бөмбөлөг тавьж хаах
- С. зөөлцийг бүрэн авч сувгийг ломбодох
- Д. зөөлцийг авч, сувгийг ариутгах, сувагт иод эсвэл унитолтой трунд орхих

- Е. зөөлцийг авч, хурц үрэвслийг намжаан, физик эмчилгээ хийх

/14./ Ямар зорилгоор сувгийн эмчилгээнд уураг задлагч ферментүүдийг хэрэглэдэг вэ?

- А. сурвалжийн оройд үүссэн үрэвслийг намжаах
- В. сурвалжийн суваг дахь эмгэг төрөгч нянд үйлчлэх
- С. зөөлцийн задралыг уусгах
- Д. зөөлцийг үхүүлэх
- Е. шүдний холбоосыг уусгах зорилгоор

/15./ Холбоосын архаг мөхлөнгөрших үрэвслийн эмчилгээний үед эхний ирэлтийн дараа заавал онгорхой орхино. Яагаад гэвэл холбоосны архаг мөхлөнгөрших үрэвсэл нь удаан хугацааны туршид байгаа холбоосын архаг үрэвсэл юм.

/16./ Сурвалжийн оройн уйланхайг мэс заслын аргаар авах ёстой. Учир нь уйланхай хэзээ нэгэн цагт сэдэрч болно.

/17./ Холбоосын цочмог үрэвслийн үед шүдний хөндийг бүрэн нээхэд мэдээ алдуулалт хэрэглэдэггүй. Учир нь шүдний зөөлц нь үхэжсэн байдаг.

/18./ Байнгын шүдний системний гипоплази үүсгэх шалтгааныг дурьдана уу.

- A. ундны усан дахь фторын хэмжээ багасах
- B. жирэмсэн эхийн хоол тэжээлийн дутагдал
- C. эхийн жирэмсний үеийн өвчлөл
- D. хүүхдийн нярай үеийн өвчлөл
- E. сүүн шүдний гэмтэл

/19./ Байнгын шүдний хэсгийн гипоплази үүсэхээс урьдчилан сэргийлэх аргыг дурьдана уу.

- A. эрдэсжүүлэх эмчилгээ
- B. хүүхдийг тэжээллэг хүнсээр хооллох
- C. сүүн шүдийг цаг алдалгүй зөв эмчлэх
- D. эхийг жирэмсэн байхад нь хяналтанд байлгах
- E. хүүхдэд тетрациклиний бүлгийн эм хэрэглүүлэхгүй байх

/20./ Ундны усан дахь фторын хэмжээ хэд болоход шүд толботох өвчин үүсэх вэ?

- A. 1 мг/л
- B. 1.5 мг/л-ээс дээш
- C. 2 мг/л
- D. 4 мг/л
- E. 0.8 мг/л

/21./ Шүд толботох өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг тоочно уу.

- A. эрдэсжүүлэх эмчилгээ
- B. хамгаалалт хэрэглэх
- C. ундны усыг солих
- D. тогтмол фтортой оогоор шүдээ угаах
- E. жирэмсэн байхдаа эм хэрэглэхгүй байх

/22./ Шүд толботох өвчний шархлаат хэлбэрийн эмчилгээг тоочно уу.

- A. хуванцар ломбо тавих
- B. цайруулах ба эрдэсжүүлэх эмчилгээ
- C. эрдэсжүүлэх
- D. шүдийг авах
- E. содтой усаар зайлуулах

/23./ Шүд толботох өвчний толбот хэлбэрийн эмчилгээг тоочно уу.

- A. хуванцар ломбоор сэргээх
- B. цайруулах ба эрдэсжүүлэх эмчилгээ
- C. фтортлак түрхэх
- D. шүдийг авах
- E. содтой усаар зайлуулах

/24./ Несовершенный амело-дентино-генезийн шалтгааныг тоочно уу.

- A. жирэмсэн эхийн архаг өвчин
- B. хүүхдийн нярай үеийн хоол тэжээлийн дутагдал
- C. паалан ба тугалмайн хөгжлийн удамшлын хямрал
- D. жирэмсэн байхдаа эм их хэрэглэх
- E. хүүхдийн бие махбодын ерөнхий өвчлөлүүд

/25./ Шүд толботох өвчний үед зөвхөн 1шүд гэмтэх тохиолдол байх уу?

- A. үгүй
- B. байж болно
- C. өвчний хэлбэрээс хамаарна
- D. өвчний явцаас хамаарна
- E. фторын агууламжаас хамаарна

/26./ Шүдний хатуу эдийн шалбархай ихэвчлэн хаана үүсдэг вэ?

- A. зөвхөн үүдэвчийн гадаргад
- B. шүдний бүх гадаргад
- C. зөвхөн зажлах гадаргад

D. хэлэн талын гадаргад

E. түшилцэх гадаргад

/27./ Сурвалжийн ямар түвшингээр хугарсан үед шүдийг хадгалан эмчилж болох вэ?

A. 1/3

B. 1/2

C. 2/3

D. 3/4

E. 4/5

/28./ Шүдний эмгэг элэгдлийн үед паалан ба тугалмайн гэмтэл хаана байрлах вэ?

A. үүдэвчийн гадарга ба таслах ирмэг

B. таслах ирмэг ба зажлах гадарга

C. зажлах ба хэлэн гадарга

D. хэлэн ба үүдэвчийн гадарга

E. шүдний бүх гадарга

/29./ Хатуу эдийн шалбархайн эмнэл зүйн шинж тэмдэгийг тоочно уу.

A. ёроол нь толигор хатуу, зууван дугуй хэлбэртэй

B. ёроол нь зөөлөн, нэг цэгт өвдөлттэй

C. цөгцний үүдэвчийн гадаргад олон тооны толботой

D. шүдний хүзүүгээр цэхэр зураасуудтай, паалан барзгар хөвсгөр

E. шүдний хүзүүгээр буйл паалангийн гэсэн 2 гадаргатай хатуу эдийн эмгэгтэй, паалан тугалмай хатуу

/30./ Халдварын гаралтай холбоосын цочмог үрэвслийн шалтгааныг нэрлэнэ үү.

A. зөөлцийн цочмог тархмал үрэвсэл

B. шүдний гэмтэл

C. өнгөц цоорол

D. шүд цоорох өвчний дунд үе

E. цоорлын бус гаралтай шүдний хатуу эдийн эмгэгүүд

/31./ Холбоосын цочмог хордлогот үрэвслийн эмнэл зүйн шинжийг дурьдана уу.

A. шүдээр юм хазахад өвдөнө

B. нүүрний зөөлөн эдийн хаван

C. буйлан дээрхи идээт цорго

D. хэл хавдаж хавагнасан

E. хоол залгихад хөндүүртэй

/32./ Холбоосын архаг мөхлөнгөрших үрэвслийн үеийн рентген зурагт гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү.

A. тодорхой хил хязгааргүй, янз бүрийн хэмжээтэй ясны эдийн сийрэгжилтын голомт

B. тодорхой хил хязгаартай, 5 мм хүртэл хэмжээтэй дугуй ба зууван хэлбэртэй ясны эдийн сийрэгжилтийн голомт

C. шүдний сурвалжийн орой хэсгийн холбоосын завсар өргөссөн

D. тодорхой хил хязгаартай, 1 см-с дээш хэмжээтэй дугуй ба зууван хэлбэртэй ясны эдийн сийрэгжилтийн голомт

E. рентген зурагт ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

/33./ Амны салстын архаг дахилтат шархлаат үрэвслийн үед ам зайлуулах антисептик уусмалыг сонгоно уу.

- A. ургамлын ханд, чанамал
- B. антибиотиктэй уусмал
- C. хлоргексидиний уусмал
- D. спиртийн уусмал
- E. виркон

/34./ Амны салстын архаг дахилтат шархлаат үрэвслийн афтын эдгэрэлтийг түргэсэх зорилгоор юу хэрэглэх вэ?

- A. флореналын тос
- B. нохойн хошууны тос
- C. клотримазолын тос
- D. фурациллин
- E. ус төрөгчийн хэт исэл

/35./ Ирмэгийн буйл гэж юуг хэлэх вэ?

- A. буйлны хөхлөг ба шүдийг тойрон байгаа буйл
- B. буйлны ховилын нэг хана
- C. түүшин сэртэнг бүрхэж байгаа буйл
- D. шүдний оройн хэсгийн буйл
- E. хоёр шүдний хоорондох буйл

/36./ Хэвийн үед буйлны ямар хэсгийн хучуур эд эвэршдэггүй вэ?

- A. буйлны ховил
- B. хөхлөг
- C. түүшийн буйл
- D. буйл эвэршдэггүй
- E. үүдэвчийн буйл

/37./ Эрүүл буйлны ховил юуг өөртөө агуулах вэ?

- A. цус
- B. шингэн
- C. буйлны шингэн
- D. мөхлөнгөр эд
- E. шүлс

/38./ Түүшийн буйл юунаас тогтох вэ?

- A. хучуур эд ба ясны хальс
- B. хучуур эд ба салстын үндсэн давхарга
- C. хучуур эдийн, салстны үндсэн ба доод давхарга
- D. хучуур эд ба ясжмаг эд
- E. хучуур эд

/39./ ШТЭҮӨ нь ямар өвчин вэ?

- A. үрэвсэлт
- B. үрэвсэл-тэжээлийн дутагдлаас үүссэн
- C. тэжээлийн дутагдлаас
- D. хавдрын улмаас үүссэн
- E. удамшлын өвчин

/40./ ШТЭ-ийн хатингаршил нь ямар өвчин бэ?

- A. үрэвсэлт
- B. үрэвсэл-тэжээлийн дутагдлаас үүссэн
- C. тэжээлийн дутагдлаас
- D. хавдрын улмаас үүссэн
- E. удамшлын өвчин

/41./ Буйлны үрэвслийн үед эрт илрэх шинж тэмдэг нь юу вэ?

- A. буйлны хөхлөгийн хэлбэр алдагдах
- B. буйл шүдний эмгэг хөндийн гүн 3 мм
- C. сэтгүүрдэхэд буйлнаас цус гарах
- D. буйл хатингарших

- Е. буйлнаас аяндаа цус гарах
- /42./ Буйлны улайлтат үрэвсэл ямар өвчин вэ?
- А. үрэвсэлт
 - В. тэжээлийн дутагдлаас үүссэн
 - С. үрэвсэл - тэжээлийн дутагдлаас үүссэн
 - Д. удамшлын
 - Е. төрөлхийн
- /43./ Буйлны томролтот үрэвслийн ширхэглэг хэлбэрийн эмчилгээ юу вэ?
- А. гингивотомия
 - В. кюретаж
 - С. гингивозектомия
 - Д. эмийн эмчилгээ
 - Е. УВЧ шарлага
- /44./ Буйлны шархлаат үхжилт үрэвслийн үед ямар бичил биетэн зонхилох вэ?
- А. стафилококк, спирохетүүд
 - В. спирохетүүд, фузобактерүүд
 - С. фузобактерүүд, лактобациккүүд
 - Д. мөөгөнцрүүд
 - Е. алтлаг стафилококк
- /45./ Буйлны улайлтат үрэвслийн ялгах онош юу вэ?
- А. ШТЭҮӨ
 - В. фиброматоз
 - С. ШТЭ хатингаршил
 - Д. герпетический гингивостоматит
 - Е. эпулис
- /46./ Буйлны томролтот үрэвслийн ширхэглэг хэлбэрийн ялгах онош юу вэ?
- А. ШТЭҮӨ
 - В. фиброматоз
 - С. ШТЭ хатингаршил
 - Д. герпетический гингивостоматит
 - Е. эпулис
- /47./ Буйлны шархлаат үхжилт хурц үрэвсэл Венсаны ялгах онош юу вэ?
- А. ШТЭҮӨ
 - В. фиброматоз
 - С. ШТЭ хатингаршил
 - Д. герпетический гингивостоматит
 - Е. эпулис
- /48./ Буйл- шүдний хуурамч эмгэг хөндий хаана үүсэх вэ?
- А. буйл
 - В. буйл ба холбоос
 - С. буйл, холбоос, түүшин яс
 - Д. буйл, түүшин яс
 - Е. түүшин яс
- /49./ Ямар өвчний үед буйл шүдний эмгэг хөндий илрэх вэ?
- А. ШТЭҮӨ
 - В. ШТЭ хатингаршил
 - С. шүдний холбоос эдийн цочмог үрэвсэл
 - Д. шүд цоорох өвчин
 - Е. шүдний хатуу эдийн эмгэг
- /50./ Буйлны шамралт хэдийд эхлэх вэ?

- A. Буйлны улайлтат үрэвсэл
- B. ШТЭ хатингаршил
- C. буйлны томролтот үрэвсэл
- D. шүд цоорох өвчин
- E. шүдний хатуу эдийн эмгэг

/51./ ШТЭҮӨ-ний дунд хэлбэрийн үед буйл шүдний эмгэг хөндийн гүн ямар байх вэ?

- A. 3-4 мм
- B. 4-5 мм
- C. 5 мм-с их
- D. 0.5-2 мм
- E. 2-2.5 мм

/52./ ШТЭҮӨ-ний хүнд хэлбэрийн үед буйл шүдний эмгэг хөндийн гүн ямар байх вэ?

- A. 3-4 мм
- B. 4-5 мм
- C. 5 мм-с их
- D. 0.5-2 мм
- E. 2-2.5 мм

/53./ ШТЭҮӨ-ний хүнд хэлбэрийн ялгах онош юу вэ?

- A. буйлны улайлтат үрэвсэл
- B. буйлны томролтот үрэвсэл
- C. шүдний тулгуур эдийн уусалт
- D. ШТЭҮӨ-ний хөнгөн хэлбэр
- E. ШТЭ хатингаршил

/54./ ШТЭҮӨ-ний хөнгөн хэлбэрийн үед түүш хоорондын таславчийн шимэгдэлт рентген зурагт ямар байх вэ?

- A. өөрчлөлтгүй
- B. 1/3 нь шимэгдсэн
- C. 1 /2 нь шимэгдсэн
- D. 2/3 нь шимэгдсэн
- E. 1/4 шимэгдсэн

/55./ ШТЭҮӨ-ний дунд хэлбэрийн үед түүш хоорондын таславчийн шимэгдэлт рентген зурагт ямар байх вэ?

- A. өөрчлөлтгүй
- B. 1/3 нь шимэгдсэн
- C. 1 /2 нь шимэгдсэн
- D. 2/3 нь шимэгдсэн
- E. 1/4 шимэгдсэн

/56./ ШТЭҮӨ-ний хүнд хэлбэрийн үед түүш хоорондын таславчийн шимэгдэлт рентген зурагт ямар байх вэ?

- A. өөрчлөлтгүй
- B. 1/3 нь шимэгдсэн
- C. 1 /2 нь шимэгдсэн
- D. 2/3 нь шимэгдсэн
- E. 1/4 шимэгдсэн

/57./ ШТЭ-ийн өвчнийг эмчлэхдээ ямар шалгуураар мэс заслын аргыг сонгох вэ?

- A. зовиур
- B. буйл шүдний эмгэг хөндийн гүн
- C. өвчний үргэлжилсэн хугацаа
- D. өвчтөний ерөнхий биеийн байдал

- Е. өвчтөний нас
- /58./ Буйл шүдний эмгэг хөндийн гүн 3-4 мм үед юү хийх вэ?
- А. кюретаж
 - В. нээлттэй кюретаж
 - С. лоскутны хагалгаа
 - Д. эмийн эмчилгээ
 - Е. ажиглах
- /59./ Буйл шүдний эмгэг хөндийн гүн 4-6 мм үед юү хийх вэ?
- А. кюретаж
 - В. нээлттэй кюретаж
 - С. лоскутны хагалгаа
 - Д. эмийн эмчилгээ
 - Е. ажиглах
- /60./ Өнгөрийг төгс цэвэрлэх нь тулгуур эдийн өвчний эмчилгээний чухал хэсэг. Учир нь өнгөрийг цэвэрлэснээр шүдний чулуу үүсэх нь саатна.
- /61./ Буйлны үрэвслийн шархлаат хэлбэрийн үед буйлнаас цус гардаг. Иймээс энэ үед өвчингүй байдаг.
- /62./ Никольскийн шинж тэмдэг илрэх өвчнийг дурьдана уу.
- А. вульгарная пузырчатка
 - В. тэмбүү
 - С. олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвсэл
 - Д. шүд цоорох өвчин
 - Е. шүдний тургуур эдийн өвчин
- /63./ Ямар процессын үед эс хоорондын холбоос хайлснаас өргөст давхаргын эсүүдэд дегенератив өөрчлөлт гарах вэ?
- А. спонгиоз
 - В. акантоз
 - С. акантолиз
 - Д. паракератоз
 - Е. папиломатоз
- /64./ Эсийн шинжилгээнд акантолитический эсүүд хэдийд илрэх вэ?
- А. вульгарная пузырчатка
 - В. олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвсэл
 - С. миларно-язвенный туберкулез
 - Д. хавтгай улаан үлд
 - Е. ам гэмтэх
- /65./ Цусны гемоглобины үзүүлэлт ямар өвчний үед өөрчлөгддөг вэ?
- А. хавтгай улаан үлд
 - В. лейкоз
 - С. төмөр дутагдлын улмаас үүссэн цус багадалт
 - Д. АСАДШ үрэвсэл
 - Е. мөөгөнцөр
- /66./ Хавтгай улаан үлдийн ердийн хэлбэрийн үед илрэх эмнэл зүйн шинж тэмдэгийг тоочно уу.
- А. салстын улайсан суурин дээр гүвдрүү үүснэ
 - В. салстын хэвийн өнгөтэй суурин дээр гүвдрүү үүснэ
 - С. салстын улайж хавагнасан суурин дээр гүвдрүү ба шархлаа үүснэ
 - Д. салстын хэвийн өнгөтэй суурин дээр цэврүү үүснэ
 - Е. салстад нэлэнхүйдээ цэврүүнцрүүд үүснэ
- /67./ Хавтгай улаан үлдийн шүүдэст-улайлтат хэлбэрийн үед илрэх эмнэл зүйн шинж тэмдэгийг тоочно уу.

A. салстын улайсан суурин дээр гүвдрүү үүснэ
B. гүвдрүү нь тодорхой зураглал үүсгэнэ
C. салстын улайсан суурин дээр гүвдрүү ба шархлаа үүснэ
D. салстын хэвийн өнгөтэй суурин дээр цэврүү үүснэ
E. салстад нэлэнхүйдээ цэврүүнцрүүд үүснэ
/68./ Хавтгай улаан үлдийн шархлаат-шарх хэлбэрийн үед илрэх эмнэл зүйн шинж тэмдэгийг тоочно уу.

A. салстын улайсан суурин дээр гүвдрүү үүснэ
B. гүвдрүү нь тодорхой зураглал үүсгэнэ
C. салстын улайсан суурин дээр гүвдрүү ба шархлаа үүснэ
D. салст бүхэлдээ хавдаж хавагнасан байна
E. цус гарамтгай, цэврүүнцэр үүссэн байна
/69./ Хавтгай улаан үлдийн ердийн хэлбэрийн ялгах оношийг дурьдана уу.

A. хронический гиперпластический кандидоз
B. хавтгай цагаан үлд
C. хомхой долоох
D. олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвсэл
E. эмийн харшил
/70./ Олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвслийн үед шархлаанаас шинжилгээ авч үзэхэд юу харагдах вэ?

A. атипичны хучуур эсүүд
B. аварга эсүүд
C. микоцитүүд
D. полибласт бүхий өвөрмөц бус үрэвслийн зураглал
E. цайвар спирохет
/71./ Олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвслийн хөнгөн үед цусанд гарах өөрчлөлтийг дурьдана уу.

A. лейкоцитоз, эозинофилия
B. цусны үзүүлэлтүүд хэвийн
C. анизоцитоз, пойкиоцитоз
D. агранулоцитоз
E. лейкопения
/72./ Олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвслийн хүнд үед цусанд цусанд гарах өөрчлөлтийг дурьдана уу.

A. лейкоцитоз, эозинофилия
B. цусны үзүүлэлтүүд хэвийн
C. анизоцитоз, пойкиоцитоз
D. агранулоцитоз
E. лейкопения
/73./ Мөөгөнцөрийн гаралтай амны булангийн цууралтын эмчилгээнд хэрэглэх бэлдмэлийг сонгоно уу.

A. леворины 2% тос
B. эритромицины 2%
C. 2% иодот спиртийн тос
D. синтомицины эмульс
E. антибиотekuуд
/74./ Буйл салтын шархлаат үхжилт үрэвсэл Венсаны үед шүдийг

хэдийд эмчлэх вэ?

- A. хурц үед
- B. үрэвсэл намжсаны дараа
- C. архаг үед
- D. эмчлэх шаардлагагүй
- E. анхын ирэлтээр

/75./ Амны салстын мөөгөнцөрт өвчнүүдийг нэрлэнэ үү.

- A. буйл салстын шархлаат үхжилт үрэвсэл Венсана
- B. хомхой долоох
- C. мөөгөнцөр
- D. могой яр
- E. АСАДШ үрэвсэл

/76./ Микотический глосситын үед хэсгийн эмчилгээнд декаминтэй карамелийг яаж хэрэглэх вэ?

- A. өдөрт 3 удаа
- B. хоолны өмнө
- C. өдөрт 4-6 удаа хоолны дараа
- D. өдөрт 1 удаа
- E. 7 хоногт 2 удаа

/77./ Candid-ын мөөг ямар орчинд ургах вэ?

- A. саармаг
- B. хүчиллэг
- C. сул шүлтлэг
- D. орчин хамаарахгүй
- E. сул хүчиллэг

/78./ Мөөгөнцөрийн эсрэг бэлдмэлүүдийг нэрлэнэ үү.

- A. диазолин ба оксациллин
- B. оксациллин ба метронидазол
- C. метронидазол ба нистатин
- D. нистатин ба леворин
- E. амоксациллин ба метронидазол

/79./ Олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвслийн хүнд хэлбэрийг нэрлэнэ үү.

- A. Бехчетын хам шинж
- B. Сеттоны афт
- C. Шегрены хам шинж
- D. Розенталийн хам шинж
- E. Стивенс-Джонсоны хам шинж

/80./ АСАДШҮ-ийн үед аманд гарах элементийг нэрлэнэ үү.

- A. толбо
- B. гүвдрүү
- C. бэлцрүү
- D. цэврүүнцэр
- E. афт

/81./ АСАДШҮ-ийн гэмтсэн салстыг арчлахад юуг хэрэглэх вэ?

- A. мэдээ алдуулагч уусмал
- B. мэдээ алдуулагч уусмал ба фермент
- C. мэдээ алдуулагч, фермент, антисептик уусмал
- D. мэдээ алдуулагч, антисептик, фермент, кератопластик
- E. мэдээ алдуулагч, фермент, асептик

/82./ Могой ярын үүсгэгчийг сонгоно уу.

- A. фузоспирохетүүд
- B. энгийн герпесын вирус

С. салхин цэцгийн вирус

Д. коксакийн вирус

Е. гриппын вирус

/83./ Вирозол, Бонафтон, Зовиракс бэлдмэлийн үйлчилгээг тоочно уу.

А. үрэвслийн эсрэг

В. десенсблизирующий

С. аминдэм

Д. вирусын эсрэг

Е. халуун бууруулах

/84./ Ямар өвчний үед амны хөндийд шархлаат үхжилт өөрчлөлт үүсэх вэ?

А. лейкоплаки

В. шархлаат-үхжилт буйл салстын үрэвсэл

С. харшлын гаралтай буйл салстын үрэвсэл

Д. вирусын гаралтай салстын үрэвсэл

Е. шүлхий

/85./ Хавтгай цагаан үлд хорт хавдрын урьдал өвчин. Тиймээс шархлаат хэлбэрийн үед шархыг зүсч авч эдийн шинжилгээ хийж болохгүй.

/86./ Могой яраар өвчилсөн хүнд дархлаа тогтохгүй. Иймд хүний биеийн эсэргүйцэл сулрах үед дахин дахин өвчилнө.

/87./ Тамхичдын Таппейнерийн хэлбэрийн цагаан үлдтэй болох үед тагнайн шүлсний булчирхайнууд тод улаан харагдана. Иймд эмийн эмчилгээ хийхийн зэрэгцээ тамхи татахийг хориглоно.

/88./ Хомхой долоох өвчний үед амны хөндийн салстан дээр олон тооны цэврүүнүүд гарна. Иймд ялган оношлохдоо цэврүүнээс авсан эсийн шинжилгээгээр онош тогтооно.

/89./ (Дархлаа хомсдол)-ын тодорхойлолт

А. дархлаа урвалын нэг буюу хэд хэдэн механизм дутагдсанаас үүсэх эмгэг байдал

В. дархлаа урвалын нэг буюу хэд хэдэн механизм илүүдсэнээс үүсэх эмгэг байдал

С. дархлаа урвалын нэг механизм дутагдсанаас үүсэх эмгэг байдал

Д. дархлаа урвалын нэг механизм илүүдсэнээс үүсэх эмгэг байдал

Е. дархлаа урвалын механизм өөрчлөгдсөнөөс үүсэх эмгэг байдал

/90./ Шүдэнд зөөлөн өнгөр үүсэх, түүнд агуулагдах нянгийн бүрэлдэхүүн нь биеийн өвөрмөц бус тэсвэрт чанараас хамаардаг уу?

А. хамаарна

В. өнгөрийн байрлалаас шалтгаална

С. биеийн өвөрмөц бус тэсвэрт чанар үүнд хамаагүй

Д. амны хөндийн эрүүл ахуй сахилтаас шалтгаална

Е. хүн бүрт харилцан адилгүй

/91./ Шүдний цочмог цооролтой хүний дархлаа урвал хэрхэн өөрчлөгдөх вэ?

А. багасдаг

В. ихэсдэг

С. өөрчлөгддөггүй

Д. ихсээд багасна

Е. багасаад ихэснэ

/92./ Харшилын тодорхойлолтыг сонгоно уу.

- A. аливаа бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
- B. антиген ба гаптен шинжтэй бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
- C. антиген ба гаптен шинжтэй бодист бие махбод мэдрэгших урвал
- D. антиген бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
- E. гаптен шинжтэй бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал

/93./ Гаптен гэж юу вэ?

- A. бага молекулт уургийн нэгдэл бөгөөд эсрэг биетэй нэгдэх чанартай боловч дархлаа урвал өдөөх чанаргүй бодис
- B. дархлаа урвалыг өдөөгөөд түүний үр дүнд үүссэн эсрэг биетэй урвалд орох чанартай бодис
- C. өндөр молекулт уургийн нэгдэл бөгөөд дархлаа урвал өдөөх чанартай
- D. өндөр молекулт уургийн нэгдэл бөгөөд дархлаа урвал өдөөх чанаргүй
- E. бага молекулт уургийн нэгдэл бөгөөд дархлаа урвал өдөөх чанартай бодис

/94./ Аллерген гэж юу вэ?

- A. бие махбодыг өвөрмөц мэдрэгжүүлэгч антиген
- B. бие махбодыг өвөрмөц биш мэдрэгжүүлэгч антиген
- C. бие махбодыг өвөрмөц мэдрэгжүүлэгч гаптен
- D. бие махбодыг өвөрмөц биш мэдрэгжүүлэгч гаптен
- E. бүх хариулт буруу

/95./ Харшлын эсрэг биеийн гол ангилалыг нэрлэнэ үү.

- A. эсийн ба эдийн
- B. эсийн ба эрхтний
- C. эсийн ба шингэний
- D. шингэний ба эдийн
- E. эдийн ба эрхтний

/96./ Анафилакси шокын дараа үүсдэг антианафилакси механизм юугаар нөхцөлддөг вэ?

- A. реакин
- B. хориг эсрэг бие
- C. үл тунадасжигч эсрэг бие
- D. биеийн эд эс үхжих
- E. цусан хангамжийн дутагдал

/97./ Хуванцар шүдэлбэрийн харшлаар хэн илүү их өвчилдөг вэ?

- A. эрэгтэйчүүд
- B. эмэгтэйчүүд
- C. хүүхдүүд
- D. шилжилтийн насныхан
- E. 30-40 орчим насны эрэгтэйчүүд

/98./ Цагаан эсийн (лейкоцитын) ямар байдлыг харшлын эерэг урвал гэж тооцох вэ?

- A. цагаан эсүүд бөөнөөр байвал
- B. цагаан эсүүдийн бөөгнөрөл огт байхгүй бол
- C. бүх хэлбэрийн цагаан эсүүд тодорхойлогдож байвал
- D. харшлын урвалд цагаан эсийн үзүүлэлт хамаарахгүй

Е. савхан бөөмт цагаан эсүүд ихээр бөөгнөрсөн байвал
/99./ Анхдагч урьдчилан сэргийлэлтийн гол чиглэл нь ямар иж бүрдэл арга хэмжээнд чиглэдэг вэ?

- А. өвчин үүсэхээс сэргийлэх
- В. өвчний эмчилгээ ба хүндрэлээс сэргийлэх
- С. үйл ажиллагааны алдагдлыг сэргээх
- Д. өвчний хүндрэлээс сэргийлэх
- Е. үйл ажиллагааг сэргээх

/100./ ДЭМБ үндэсний тархвар судлалын судалгааг хэдэн жилд нэг удаа явуулахыг зөвлөдөг вэ?

- А. 1 жилд
- В. 2 жилд
- С. 3 жилд
- Д. 5 жил
- Е. 4 жилд

/101./ Нүүр амны эмчилгээний өрөөг зохион байгуулахад юу юу хэрэгтэй вэ?

А. шүдний тоног төхөөрөмж, үзлэгийн юнит, зориулалтын цомог багаж гэх мэт

В. хагалгааны ширээ, унтуулах аппарат, чагнуур, хүчилтөрөгчийн баллон гэх мэт

С. ортопантомограф, рентген аппарат

Д. шүдний тоног, төхөөрөмж, ширээ

Е. аппарат, шүдний тоног төхөөрөмж, ширээ

/102./ Борын эргэлтийн хурд ямар байхад хатуу эдийг өвдөлт багатай хэлбэржүүлэх вэ?

- А. 200-300 мян. эр/хором
- В. 80-100 мян. эр/хором
- С. 300-600 мян.эр/хором
- Д. 20-40 мян. эр/хором
- Е. 50-90 мян. эр/хором

/103./ Цинк оксид эвгенол цементийг ямар ломбоны доор хэрэглэж болохгүй вэ?

- А. амалгам
- В. силикат
- С. фосфат цемент
- Д. хуванцар
- Е. зоомол

/104./ Хүйтэн ариутгалаар юуг ариутгах вэ?

- А. өрөм, эндодонтын багаж, сэтгүүр, хямсаа, гладилка
- В. толь, иртэй багаж
- С. боолтын материал
- Д. өрөм, толь, хямсаа, сэтгүүр
- Е. бүх үзлэгийн багажийг ариутгана

/105./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх үндсэн зарчим нь юу вэ?

А. өвчингүй, иммуны бүсийг хүртэл урьдчилан сэргийлэх зорилгоор шүдний хатуу эдийг авах

В. урьдчилан сэргийлэхээр авах ба биологийн бүтэн байдлын зарчим

- С. эрүүл эдээс аль болох бага авч эмгэг эдийг бүрэн авах
- D. паалан тугалмайн заагаас аль болох дээш өрөмдөх
- Е. паалан тугалмайн заагийг аль болох давуулан өрөмдөх

/106./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх дараалал юү вэ?

- A. өвчин намдаах, үхжсэн эдийг авах, өөлөх, хөндийг өргөсгөх
- В. цоорлын хөндийг өргөсгөх, үхэжсэн эдийг авах, өөлөх
- С. цоорлын хөндийг нээж өргөсгөөд үхжсэн эдийг авах, цоорлын хөндийг хэлбэржүүлэх, ирмэгийг дарах
- D. хөндийн ирмэгийг дарах, өвчин намдаах, цоорлын хөндийг өргөсгөх
- Е. өвчин намдаах, цоорлын хөндийг хэлбэржүүлэх, ирмэгийг дарах, үхэжсэн эдийг авах

/107./ Цоорлын хөндийг ломбодох үед тусгаарлах жийргэвчээр юуг хаах вэ?

- A. цоорлын хөндийн ёроол
- В. цоорлын хөндийн хана
- С. цоорлын хөндийн хана ба ёроол
- D. цоорлын хөндийн ёроол, ханыг тугалмай паалангийн зааг хүртэл

Е. бүх хөндийг

/108./ Паалангийн ирмэгийг ямар хүчил хэрэглэж сийрэгжүүлэх вэ?

- A. хүхрийн хүчил
- В. гурван хлорт цууны хүчил
- С. ортофосфорын хүчил
- D. азотын хүчил
- Е. давсны хүчил

/109./ 24-р шүдний хөндийг ямар чиглэлд өргөсгөх вэ?

- A. урагшаа-хойшоо
- В. хацар-тагнайн
- С. тагнай талын гадарга
- D. уруул талын гадарга
- Е. дээшээ доошоо

/110./ Соёо ба үүдэн шүдний хөндийг аль гадаргаас нь нээх вэ?

- A. хэлэн
- В. хацар
- С. түшилцэх
- D. таслах ирмэг
- Е. хүзүү хэсэг

/111./ Бага араа ба араа шүдний хөндийг аль гадаргаас нь нээх вэ?

- A. хэлэн
- В. хацар
- С. түшилцэх
- D. зажлах
- Е. хүзүү хэсэг

/112./ Эндодонтын багажны номер юуг илэрхийлдэг вэ?

- A. багажны нэр
- B. үйлдвэрлэсэн улс
- C. урт
- D. өргөн
- E. багажны төрөл

/113./ Сурвалжийн сувгийг ломбодоход юу хэрэглэдэг вэ?

- A. гуттаперч
- B. силидонт
- C. силикат
- D. силицин
- E. композит

/114./ Өргөн сувгийг step-back аргаар ломбоддог. Тийм учраас хоншоорын 1-р их арааны хацар талын сувгийг энэ аргаар ломбоддог.

/115./ Түр ломбоны материалыг зөөлцийн эмчилгээний үед шүдний хөндийг хаахад хэрэглэдэг. Учир нь түр ломбыг шууд зөөлц дээр тавьж болдог.

/116./ Бонд тавихын өмнө шүдийг сайтар хүчтэй үлээлгэж хуурайшуулах хэрэгтэй. Учир нь хүчил түрхсэний дараа үүсдэг гибрид давхрага нь ломбоны тогтоцыг сайжруулдаг.

/117./ Хүнцэлийг тун хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэвэл сурвалжийн оройн эдийг цочрооно. Тийм учраас 1% иодинолыг сувагт үлдээх нь үр дүн сайтай.

/118./ Амтлах булцуу агуулдаггүй хэлний хөхлөгийг нэрлэнэ үү?

- A. утаслаг
- B. мөөгөн
- C. навчин
- D. шигтгээн
- E. цэцгэн

/119./ Өвчтөний амны хөндийн эрүүл ахуйн төлөвийг ямар үзүүлэлтээр тодорхойлох вэ?

- A. ЦЛА
- B. Эрүүл ахуйн үзүүлэлт
- C. РМА
- D. CPITN
- E. Silness Loe

/120./ $\text{Ca}_{10}(\text{PO}_4)_6(\text{OH})_2$ энэ юуны томъёо вэ?

- A. карбопатит
- B. хлорпатит
- C. брушит
- D. витлокит
- E. гидроксилпатит

/121./ Амны шингэний pH буурахад шүдний паалангийн гидроксипатитын уусалт яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. багасдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. саармагждаг
- E. уусдаггүй

/122./ Шүд цоорох өвчний толбын үед паалангийн хатуулаг чанар яаж өөрчлөгдөх вэ?

- A. буурдаг
- B. нэмэгддэг
- C. өөрчлөгдөхгүй

- D. алга болдог
- E. эрс нэмэгддэг

/123./ Ямар өвчнүүдийн үед паалангийн нэвчимтгий байдал нэмэгддэг вэ?

- A. шүд цоорох өвчний цагаан толбын үед
- B. шүд толботох өвчин
- C. гипоплази
- D. элэгдэл
- E. гиперплази

/124./ Эрдэсжилт ба эрдэсжүүлэлтийн ионы солилцоо нь юуг үзүүлэх вэ?

- A. хатуулаг чанар (микротвердость)
- B. нэвчимтгий байдал
- C. уусамтгай байдал
- D. уян хатан чанар
- E. гялалзсан байдал

/125./ Цоорлын цагаан толбын үед гэмтсэн хэсэг дэх протейны агууламж нь яаж өөрчлөгдөх вэ?

- A. ихэсдэг
- B. багасдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. алга болдог
- E. эрс ихэснэ

/126./ Цоорлын цагаан толбын үед кальцийн агууламж нь яаж өөрчлөгдөх вэ?

- A. гэмтсэн хэсэгт ихэсдэг
- B. гэмтсэн хэсэгт багасдаг
- C. паалангийн калыц багасдаг
- D. гэмтсэн хэсгийн калыц бүрэн алдагдана
- E. толбын хэмжээнээс хамаарна

/127./ Цоорлын цагаан толбын үед фосфорын агууламж нь яаж өөрчлөгдөх вэ?

- A. паалангийн найрлага дахь протейны хэмжээ ихэсдэг
- B. гэмтсэн хэсэгт багасдаг
- C. гэмтсэн хэсгийн протейны агууламж өөрчлөгдөхгүй
- D. гэмтсэн хэсгийн протейны агууламж бүрэн алдагдана.
- E. толбын хэмжээнээс хамаарна

/128./ Цоорлын цагаан толбын үед гэмтсэн хэсэг дэх фторын агууламж нь яаж өөрчлөгдөх вэ?

- A. ихэсдэг
- B. багасдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. алга болдог
- E. эрс ихэснэ

/129./ Ортофосфорын хүчлийн нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/130./ Фторид натрийн нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/131./ Физиологийн уусмалын нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/132./ Сүүний хүчлийн нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/133./ Кальци глюконатын уусмалын нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/134./ Шүдний паалангийн эрдэсжүүлэлт нь түүний ямар шинжээр тодорхойлогддог вэ?

- A. хатуулаг чанар (микротвердость)
- B. нэвчимтгий байдал
- C. уусамтгай байдал
- D. уян хатан чанар
- E. зөөлөн чанар

/135./ Ямар үед амны хөндийн шингэн шүлтлэг байх вэ?

- A. $\text{pH} < 7$
- B. $\text{pH} = 7$
- C. $\text{pH} > 7$
- D. $\text{pH} = 5$
- E. $\text{pH} = 6$

/136./ Ямар үед амны хөндийн шингэн саармаг байх вэ?

- A. $\text{pH} < 7$
- B. $\text{pH} = 7$
- C. $\text{pH} > 7$
- D. $\text{pH} = 5$
- E. $\text{pH} = 5,2$

/137./ Шүд цоорох өвчний үед өвдөлт ямар байх вэ?

- A. өөрөө аяндаа
- B. цочроогчийг арилгасны дараа өвдөх

С. зөвхөн цочроогчийн нөлөөгөөр

Д. шөнө өвдөлт өгнө

Е. механик цочруулд өвдөнө

/138./ Цоорол нь шүдний хатуу эдийн эмгэг өөрчлөлт. Иймд явцаар нь хурц өвчин гэж хэлж болох юм.

/139./ Дунд цоорлын үед цоорлын хөндий тугалмайн зааг хэтэрсэн байдаг. Иймээс мэдрэлийн төгсгөл цочирч хоол ундны зүйл орохоор өвдөлт өгдөг.

/140./ Байнгын ломбоны доор эмчилгээний жийргэвч тавьдаг. Ингэснээр түүний хортой үйлчилгээг багасгадаг.

/141./ Гүн цоорлын үед цоорлын хөндий зөөлцөд ойртсон байдаг.

Иймээс гидрокиль кальц бүхий бэлдмэлийг хэрэглэж ломбо тавина.

/142./ Дентиний давхарга нимгэрснээс цоорлын хөндийн ёроолоор их эмзэглэлтэй болдог. Иймд ФС агуулсан бэлдмэл хэрэглэвэл хоёрдогч тугалмай үүсч эмзэглэл арилна.

/143./ Блекийн 1-р ангилалын үед цоорлын хөндийг шүдний ховилын хэлбэрийг дагуулж хэлбэржүүлнэ. Учир нь цоорол шүдний төрөлхийн ховил хонхорт үүссэн байдаг.

/144./ Өнгөц цоорол нь паалан тугалмайн зааг хүрсэн байдаг. Иймээс тусгаарлах жийргэвч тавьж ломбоддог.

/145./ Шүдний хүзүүвчид үүссэн цоорлын хөндийн ёроолыг гүдгэр байдлаар хэлбэржүүлж засна. Учир нь шүдний хөндий нээгдэх эрсдэлтэй.

/146./ Гэрлээр хатуурагч хуванцар ломбо нь хатуурахдаа агшдаг. Иймээс нэг удаагийн тавих хэмжээ нь 2 мм-ээс илүү зузаан байж болохгүй.

/147./ Химийн гаралтай зөөлцийн гэмтлийн үндсэн шалтгаан нь юу вэ?

А. цоорлын хөндийг хэлбэржүүлэх үед зөөлцийг гэмтээх

В. захлах гадаргуу, таслах ирмэгийн эрчимтэй элэгдэл

С. хүчтэй үйлчлэл бүхий антисептикууд, ломбоны материалуудыг буруу хэрэглэх

Д. шүдний зөөлцийг дайрсан хурц хэлбэрийн хугарал

Е. шүдний тулгуур эдийн өвчнүүд

/148./ Зөөлцийн хурц тархмал үрэвсэл ямар хугацаанд үргэлжлэх вэ?

А. 2 хоног

В. 20 хоног

С. 30 хоног

Д. 14 хоног

Е. 1 хоног

/149./ Зөөлцийн хурц голомтот үрэвсэл ямар хугацаанд үргэлжлэх вэ?

А. 10 хоног

В. 12 хоног

С. 2 хоног

Д. 14 хоног

Е. 7 хоног

/150./ Зөөлцийн хурц голомтот үрэвслийн үед цоорлын хөндийн хаана сэтгүүрдэхэд хүчтэй өвдөх вэ?

А. 1 цэгт (цоорлын хөндийн ёроолд)

В. цоорлын хөндийн хана ба ёроолоор

С. паалан-тугалмайн заагаар

Д. цоорлын хөндийн ёроолоор нэлэнхүйдээ

Е. огт өвдөхгүй

/151./ Зөөлцийн хурц тархмал үрэвслийн үед цоорлын хөндийн хаана сэтгүүрдэхэд хүчтэй өвдөх вэ?

А. 1 цэгт (цоорлын хөндийн ёроолд)

- В. цоорлын хөндийн ёроолоор
 - С. паалан-тугалмайн заагаар
 - Д. огт өвдөхгүй
 - Е. цоорлын хөндийн ханаар
- /152./ Зөөлцийн архаг үрэвслүүдийн үед халуун хүйтний сорилд яах вэ?
- А. хүчтэй өвдөнө
 - В. цочроогчийг авмагц өвдөлт аажим намдана
 - С. өвдөхгүй
 - Д. цочроогчийг авмагц өвдөлт хурдан намдана
 - Е. механик цочроогчоос хүчтэй өвдөлт өгнө
- /153./ Зөөлцийн хурц үрэвслүүдийн үед халуун, хүйтний сорилд яах вэ?
- А. хүчтэй өвдөнө
 - В. өвдөнө
 - С. өвдөхгүй
 - Д. цочроогчийг авахад өвдөлт намдана
 - Е. сулхан нэгэн хэвийн өвдөлт өгнө
- /154./ Үрэвслийн үед зөөлцийн цахилгаан мэдрэг чанар яах вэ?
- А. ихсэнэ
 - В. буурна
 - С. өөрчлөгдөхгүй
 - Д. ихсээд буурна
 - Е. буураад ихэснэ
- /155./ Зөөлцийн үрэвслийн эмчилгээний үед ямар мэдээ алдуулалт илүү үр дүнтэй вэ?
- А. даралттай
 - В. дамжуулах
 - С. нэвчүүлэх
 - Д. холбоосын дотуур
 - Е. шавших
- /156./ Сурвалжийн сувгийн зөөлцийг амьдаар нь хадгалах эмчилгээний арга юу вэ?
- А. зөөлцийг амьдаар нь бүрэн авах
 - В. зөөлцийг амьдаар нь тайрах
 - С. зөөлцийг үхжүүлж бүрэн авах
 - Д. зөөлцийг үхжүүлж тайрах
 - Е. холимог арга хэрэглэх
- /157./ Түргэн үйлчилгээтэй үхжүүлэгч зуурмагийн үндсэн бодис болох хүчлийг нэрлэнэ үү.
- А. ацетилсалицил
 - В. хлорноватист
 - С. мышъякын ангидрид
 - Д. ортофосфор
 - Е. керсорфин
- /158./ Сувгийн эмчилгээний үед ямар зорилгоор шүдний хөндийг бүрэн нээдэг вэ?
- А. ломбоны тогтоцыг сайжруулах
 - В. сувагт чөлөөтэй ажиллах
 - С. цөгцөн хэсгийн зөөлцийг авах
 - Д. үхэжсэн эдийг бүрэн авах
 - Е. бүрэн нээх нь буруу
- /159./ Сувгийг хуурайшуулахад юу хэрэглэх вэ?

- A. гар хий шахагч
- B. машины ус ба хий шахагч
- C. унтуулагч эфир
- D. цаасан трунд
- E. хөвөн бөмбөлөг

/160./ Биологийн эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэлүүдийг сонгоно уу.

- A. эвгенолтой бэлдмэл
- B. химоотрипсин
- C. кальцийн гидроксид
- D. иодопирон
- E. дээрх бүх бэлдмэлийг хэрэглэнэ.

/161./ Шүдний эмчийн мэргэжлийн ур чадвар бүрэлдэх үе

- A. 1-10 жил
- B. 1-5 жил
- C. 1-3 жил
- D. 1-2 жил
- E. 1-4 жил

/162./ Шүдний эмчийн мэргэжлийн ур чадвар төлөвшиж тогтох үе

- A. 1-10 жил
- B. 10-15 жил
- C. 5-10 жил
- D. 3- 10 жил
- E. 4-10 жил

/163./ Шүдний эмчийн мэргэжлийн ур чадварын алтан үе

- A. 10-аас дээш жил
- B. 5-аас дээш жил
- C. 15-аас дээш жил
- D. 3- аас дээш жил
- E. 6- аас дээш жил

/164./ Олон улсын стандартын байгууллага гөлтгөнийг хэд ангилдаг вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/165./ Энгийн гөлтгөнийг зуурахад ус нунтгийн харьцаа

- A. 1:1
- B. 1:2
- C. 1:3
- D. 1:4
- E. 1:5

/166./ Чулуун гөлтгөнийг зуурахад ус нунтгийн харьцаа ямар байх вэ?

- A. 1:1
- B. 1:2
- C. 1:3
- D. 1:4
- E. 1:5

/167./ А силикон гэж аль хэвний материалыг товчоор нэрлэдэг вэ?

- A. Полиэфир
- B. Кондинсаци
- C. Полисульфид
- D. Винилполисилоксан
- E. Агар гидроколлойд

/168./ Зааг шугам (survey line) гэж юу вэ?

- A. Загварын хамгийн өргөн хэсгээр татсан шугам

- B. Тухайн байрлал дахь шүдний цөгцний хамгийн өргөн хэсгээр татсан шугам
 - C. Шүдний цөгцний хамгийн өргөн хэсгээр татсан шугам
 - D. Шүдний хамгийн гүдгэр гадаргуугаар татсан шугам
 - E. Шүдний цөгцний экватороор татсан шугам
- /169./ 0 байрлал (Zero position) гэж юу вэ?
- A. Загварын суурь босоо тэнхлэгтэй 0 градусаар байралсан
 - B. Загварын суурь хэвтээ тэнхлэгтэй 0 градусаар байралсан
 - C. Шүдэлбэр хүндийн хүчний нөлөөгөөр загварт саадгүй суух
 - D. Хоршихуйн хавтгай босоо тэнхлэгтэй 90 градусаар байралсан
 - E. Хоршихуйн хавтгай хэвтээ тэнхлэгтэй 90 градусаар байралсан
- /170./ Тээгийн гүнийг хэмжигч 1-р тавгийн хэмжээ хэдэн мм байх вэ?
- A. 0.1 mm
 - B. 0.2 mm
 - C. 0.25 mm
 - D. 0.5 mm
 - E. 0.75 mm
- /171./ Шүдэлбэрийн дизайныг төлөвлөхдөө буйлны ирмэг ба их холбогчийн хоорондын зай хэд байх вэ?
- A. 4 mm
 - B. 2 mm
 - C. 3 mm
 - D. 5 mm
 - E. 1 mm
- /172./ Цутгамал шүдэлбэрийн нумыг ямар металлаар хийдэг вэ?
- A. Алт (Au)
 - B. Титан (Ti)
 - C. Кобальт Хром (CoCr)
 - D. Никель Хром (Ni Cr)
 - E. Цагаан алт (Pt)
- /173./ Тухайн эд эрхтний эерэг дүрсийг юу гэх вэ?
- A. Хэв
 - B. Загвар
 - C. Давхар хэв
 - D. Урьдал хийц
 - E. Дан хэв
- /174./ Үүдэн шүд ямар үйл гүйцэтгэх вэ?
- A. Жижиглэх
 - B. Бутлах
 - C. Зуух
 - D. Таслах
 - E. Зуух ба таслах
- /175./ Сүүн шүдний 2 эгнээ хичнээн соёо шүдтэй вэ?
- A. 4 үүдэн шүдтэй
 - B. 4 соёотой
 - C. 4 бага араатай
 - D. 8 бага араатай
 - E. 4 агт араатай
- /176./ Хоншоор ба эрүүний шүднүүд ямар төлөвт хамгийн олон тооны цэгээр хорших вэ?
- A. Голлосон хоршихуйн
 - B. Хажуугийн хоршихуйн
 - C. Урагшилсан хоршихуйн
 - D. Голлосон харьцааны
 - E. Үелэхүйн
- /177./ Өвчтөн шинжлэх үед хүний нүүрийг дээд, дунд, доод гэж 3 хуваадаг. Үүний дунд хэсэг нь хаана байрлах вэ?

- A. Духны нугалаас болон хамрын таславчны хооронд
 - B. Хөмсөгний шугам болон хамрын таславчны хооронд
 - C. Нүдний ирмэгээр татсан шугам болон хамрын таславчны хооронд
 - D. Хөмсөг болон хамрын таславчны хооронд
 - E. Нүдний ирмэгээр болон хамрын таславчны хооронд
- /178./ Нүүрний доод өндрийг юу гэж ангилдаг вэ?
- A. Анатомийн, физиологийн
 - B. Физиологийн, физикийн
 - C. Физикийн, анатомийн
 - D. Физикийн, химийн
- /179./ Нүүрэнд үзлэг хийсний дараа амыг шинжлэхдээ эхлээд юуг тодорхойлох шаардлагатай вэ?
- A. Амны салст бүрхүүл
 - B. Ам ангайх түвшин
 - C. Эрүүний үений хөдөлгөөн
 - D. Шүдний эгнээг
 - E. Салст бүрхүүл
- /180./ Ямар зуултын үед хоршилтын мөр байхгүй байх вэ?
- A. Шулуун
 - B. Эрүүл
 - C. Заалхай
 - D. Шаамий
 - E. Зөрмөл
- /181./ Шүд түүшийн хатингаршлын хэдэн түвшин байдаг вэ?
- A. 2
 - B. 3
 - C. 4
 - D. 5
 - E. 6
- /182./ Шүд түүшийн тусгал бичлэг гэж юу вэ?
- A. Шүдний тулгуур эдийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
 - B. Амны салст бүрхүүлийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
 - C. Ам ангайх түвшинг тооцон хүснэгтэд буулгах
 - D. Амны бүрхүүлийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
 - E. Шүдний эдийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
- /183./ Онош гэж юу вэ?
- A. Эмч нарын онол туршлагын үр дүнд хийж буй оюун ухааны үйлдэл
 - B. Эмч нарын эмнэлзүйн сэтгэлгээний үр дүнд өвчний мөн чанарын тухай хийж буй оюун ухааны дүгнэлт
 - C. Эмч нарын эмнэлзүйн сэтгэлгээний үр дүнд өвчний мөн чанарын тухай өвчний нэр томъёог ашиглан бичсэн оюун ухааны дүгнэлт
 - D. Эмч нарын эмнэлзүйн үр дүнд өвчний мөн чанарын тухай хийж буй оюун ухааны дүгнэлт
 - E. Эмч нарын өвчний мөн чанарын тухай өвчний нэр томъёог ашиглан бичсэн оюун ухааны дүгнэлт
- /184./ Шүд түүшийн тусгал бичлэгт эрүүний түүшийн хатингаршлыг Келлер хэд ангилсан бэ?
- A. 1
 - B. 2
 - C. 3
 - D. 0
 - E. 4
- /185./ Шүд түүшийн тусгал бичлэгт хоншоорын түүшийн хатингаршлыг Шредер хэд ангилсан бэ?
- A. 1

- B. 2
- C. 3
- D. 0
- E. 4

/186./ Шүдний эгнээний дунд хэмжээний согогийн үед хэдэн шүд байхгүй байх вэ?

- A. 1-13
- B. 1-3
- C. 13
- D. 4-6
- E. 10-12

/187./ Шүдний эгнээний бага хэмжээний согогийн үед хэдэн шүд байхгүй байх вэ?

- A. 1-13
- B. 4-5
- C. 13
- D. 1-3
- E. 10-12

/188./ Шүдний эгнээний их хэмжээний согогийн үед хэдэн шүд байхгүй байх вэ?

- A. 1-13
- B. 4-5
- C. 13
- D. 6-с дээш
- E. 10-12

/189./ Шүдний эгнээний урд хэсгийн согог Кеннедийн хэддүгээр ангилалд хамаарах вэ?

- A. I
- B. II
- C. III
- D. IV
- E. V

/190./ Шүдний эгнээний нэг талын төгсгөлийн согог Кеннедийн хэддүгээр ангилалд хамаарах вэ?

- A. I
- B. II
- C. III
- D. IV
- E. V

/191./ Нэг талын хөвөөлсөн шүдтэй шүдний эгнээний согог Кеннедийн хэддүгээр ангилалд хамаарах вэ?

- A. I
- B. II
- C. III
- D. IV
- E. V

/192./ Гүүрэлсэн шүдэлбэрт дасах хугацаа

- A. 2-3 хоногоос 10 хоногт
- B. 10 хоногоос 15 хоногт
- C. 15 хоногоос 20 хоногт
- D. 10 хоногоос 1 сард
- E. 7 хоногт

/193./ Гүйцэтгэх үйлийн хэт ачаалал өгдөг хоршилтыг ямар хоршилт гэдэг вэ?

- A. Гэмтлийн хоршилт
- B. Эрүүл хоршилт
- C. Физиологийн хоршилт
- D. Гүн зуулт
- E. Энглийн I

/194./ Уран тагнайн тухайд шүдэлбэрийн суурь 'A' шугамаас хир айтай байх ёстой вэ?

- A. 'А' шугамд арай хүрэхгүй байх
 - B. 'А' шугамыг давж байрлах
 - C. 'А' шугамаас зайтай байрлах
 - D. 'А' шугамтай давхцаж байрлах
 - E. 'А' шугамтай байрлах
- /195./ Хоншоорын үүдэн хэсгийн түүшин сэртэнг заавал шүдэлбэрээр хаах нь :
- A. Гоо сайханд чухал нөлөөтэй
 - B. Түүнийг улам тогтвортой болгоно
 - C. Шүдэлбэрийн бүтцэд заавал оролцоно
 - D. Түүнийг улам сайн болгоно
 - E. Шүдэлбэрийн бүтцэд оролцоно
- /196./ Түүшин сэртэн хэвийн байгаа нөхцөлд үүдэн хэсэгт шүдэлбэрийн суурийг яаж хийх вэ?
- A. Бүтэн хийдэг
 - B. Бүтэн хийдэггүй
 - C. Уруул талын хэсгийг чөлөөлж бүтэн хийдэггүй
 - D. Уруул талын хэсгийг чөлөөлж хийдэггүй
- /197./ Дэгээ нь шүдэлбэрийг тогтоох ямар аргад ордог вэ?
- A. Механик
 - B. Анатоми
 - C. Хосолмол
 - D. Физик
 - E. Хосолсон
- /198./ Дэгээ нь ямар эд ангиудаас бүрдэх вэ?
- A. Мөр,бие,хумс
 - B. Мөр,сүүл,хоршихуйн даравч
 - C. Мөр,бие,хумс,сүүл,хоршихуйн даравч
 - D. Мөр,бие, хоршихуйн даравч
 - E. Мөр,хумс,сүүл,хоршихуйн даравч
- /199./ Шүдний цөгцийг бүслэж байгаа пүршлэг хэсгийг нэрлэнэ үү?.
- A. Дэгээний хумс
 - B. Дэгээний мөр
 - C. Дэгээний бие
 - D. Дэгээний сүүл
 - E. Дэгээний үзүүр
- /200./ Дэгээний байрлал ямар байрлалаар тодорхойлогдох вэ?
- A. Шүдний анатомийн хэлбэр
 - B. Шүдний босоо тэнхлэгийн байрлал
 - C. Дэгээ байрлаж байгаа шүдний босоо тэнхлэг шүдний экватор хоёрын огтлолцолын доод хэсэгт, шүдгүй талын шүдний мөрлөх цэг, медиал талын мөрлөх цэг
 - D. Шүдний хэлбэр, шүдний босоо тэнхлэгийн байрлал
 - E. Шүдний анатомийн хэлбэр, шүдний тэнхлэгийн байрлал
- /201./ Дэгээний сүүл хаана байрлах вэ?
- A. Сүүлийг шүдэлбэрийн суурийн тагнай талд
 - B. Сүүлийг шүдэлбэрийн суурийн хэл талд
 - C. Сүүлийг хиймэл шүдэн дор байх шүдгүй түүшийн ирмэгийн дагуу
 - D. Сүүлийг хиймэл шүдэн дор түүшийн ирмэгийн дагуу
 - E. Сүүлийг шүдгүй түүшийн ирмэгийн чиглэлийн дагуу
- /202./ Дэгээг гүйцэтгэх үйлээр нь хэрхэн ангилах вэ?
- A. Тулан тогтоох дэгээ
 - B. Тулах дэгээ
 - C. Тогтоох дэгээ
 - D. Тулан дэмжих дэгээ
 - E. Тулан дарах дэгээ
- /203./ Хосолмол дэгээ гэж юу вэ?
- A. Тулах дэгээг тогтоох дэгээтэй хослуулах

- B. Тулах дэгээг тулан тогтоох дэгээтэй хослуулах
 - C. Тулан тогтоох дэгээг тогтоох дэгээтэй хослуулах
 - D. Тулан тогтоох дэгээтэй хослуулах
 - E. Тулах дэгээг тогтоох дэгээтэй хослуулахгүй
- /204./ Дэгээ хийхэд зориулж ямар голчтой ган утсыг хэрэглэдэг вэ?
- A. 0,8 мм
 - B. 0,6 мм
 - C. 0,6-1 мм
 - D. 1мм
 - E. 0.3-1 мм
- /205./ Матмал хоёр мөртэй даравчтай ган дэгээг ямар утсаар хийдэг вэ?
- A. 0,8-1,0мм-н зэвэрдэггүй ган утас
 - B. 0,6-0,8мм-н зэвэрдэггүй ган утас
 - C. 0,8-1,2 мм-н зэвэрдэггүй ган утас
 - D. 1,0-1,2 мм-н зэвэрдэггүй ган утас
 - E. 0,5-1,3 мм-н зэвэрдэггүй ган утас
- /206./ Тохмол дэгээг ямар шүдэнд хэрэглэх вэ?
- A. Үүдэн бүлэг шүдэнд
 - B. Хажуугийн бүлэг шүдэнд
 - C. Араа бүлэг шүдэнд
 - D. Хажуугийн араа бүлэг шүдэнд
 - E. Соёо бүлэг шүдэнд
- /207./ Шүд түүшийн дэгээ гэж юу вэ?
- A. Уруул талаас шахмал шүдэлбэрийн хуванцар суурийг үргэлжлүүлсэн сэртэнг хэлнэ.
 - B. Шүдний бүслүүрийн дээгүүр байрласан дэгээг хэлнэ
 - C. Уруул талаас шахмал шүдэлбэрийн хуванцар сууриас ангид байрлах дэгээг хэлнэ.
 - D. Уруул талаас шүдэлбэрийн суурийг үргэлжлүүлсэн сэртэнг хэлнэ.
 - E. Шүдний тэнхлэгийн дээгүүр байрласан дэгээг хэлнэ.
- /208./ Хуванцар дэгээг шүдний бүслүүрээр бус түүшин салстын нугалаагаар байрласан суурийн үргэлжлэлийг юу гэж нэрлэх вэ?
- A. Шүд-түүшийн дэгээ
 - B. Буйлны дэгээ
 - C. Шүд буйлны дэгээ
 - D. Шүдний дэгээ
 - E. Түүшийн дэгээ
- /209./ Дэгээг шүдэлбэрийн суурьтай холбох ямар аргууд байдаг вэ?
- A. Тогтвортой,тогтворгүй
 - B. Хатуу,пүршлэг,үений
 - C. Хагас тогтвортой,тогтворгүй
 - D. Хатуу,үений
 - E. Хатуу,пүршлэг,үений суурийн
- /210./ Матмал дэгээ бэхлэх тулгуур шүдийг сонгож авахад эсрэг заалт аль нь вэ?
- A. Тулгуур шүд хөдөлгөөнгүй тогтвортой байх
 - B. Тулгуур шүд анатомийн зөв хэлбэртэй байх
 - C. Тулгуур шүднүүд параллель байх
 - D. Тулгуур шүд болон түүний эсрэг талын шүдний харьцааг харгалзах шаардлагагүй
 - E. Тулгуур шүд болон түүний эсрэг талын шүдний харьцааг харгалзах
- /211./ Эмнэл зүйн цөгц намхан байх нөхцөлд ямар төрлийн дэгээ хийх нь тохиромжтой вэ?
- A. Углаа дэгээний систем
 - B. Тохом дэгээ
 - C. Уртасгасан дэгээ
 - D. Богиносгосон дэгээ
 - E. Хосолсон дэгээний систем
- /212./ Дээд талын шүдэлбэрийн нум салст бүрхүүлээс хэдэн мм-н зайтай байх ёстой вэ?
- A. 0,7 мм

- B. 0,3 мм
- C. 0,5 мм
- D. 1,0 мм
- E. 1,1 мм

/213./ Шүдний эгнээнд авагддаггүй чиг тавихад ямар зохиомжийг сонгох вэ?

- A. Шугаман
- B. Цэгчилсэн
- C. Шугаман ба цэгчилсэн
- D. Хоршилтоос хөндийрсэн байна
- E. Бүх гадаргаара хоршино

/214./ Хэв авахад гөлтгөнийг юугаар зуурах вэ ?

- A. Нэрмэл усаар
- B. Марганцийн уусмалаар
- C. Давсгүй усаар
- D. Ингибитор бүхий уусмалаар
- E. 3%-ын давсны уусмалаар

/215./ Шүдэлбэрийн урьдал хийцийг эмнэл зүйн хэдэн аргаар шалгах вэ?

- A. 1
- B. 4
- C. 2
- D. 8
- E. 5

/216./ Альгинатаар авсан хэвийг загвар цутгахын өмнө хэрхэн бэлтгэх вэ?

- A. Ариутгах
- B. Хэвээ усаар зайлах
- C. Илүүдэл усыг сэгсэрч агаараар шүршиж зайлуулах
- A. Нүүрний олон ясны гэмтэл
 - B. Ясны /нягт / давхарга олон тооны уйланхайн сүүдэр харагдана
 - C. Эрүүний булан салаа орчим олон тооны ясны үрэвслийн голомт харагдана
 - D. Яс тархмал хэлбэрээр зузаарч, сийрэгжиж /бүдэг шилний/ зураг харагдана
 - E. Эрүү ясны зузаарал харагдана
- /434./ Эрүүний төвийн саркомын эрт илрэх шинжийг нэрлэнэ үү?
- A. Шүлс ялгаралт ихсэх, чичрэх, эрүүнд бөгж хэлбэрийн нэвчдэс үүсэх
 - B. Ам хуурайших, шүд үе үе хүчтэй өвдөх
 - C. Шүд хөдөлгөөнтэй болох, үе үе лугшиж өвдөх, юм зажлихад хөндүүрлэх
 - D. Эрүүн доогуур хавдах
 - E. Юм залгихад хөндүүрлэж өвдөх

/435./ 1. Эрүү гурамсан мэдрэлийн аль салаагаар мэдрэлжүүлэгдэх вэ?

- A. A. I салаа
- B. B. II салаа
- C. C. III салаа
- D. D. IV салаа
- E. E. V салаа

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛД **НҮҮР АМНЫ ИХ ЭМЧИЙН** МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН **ЖИШИГ СОРИЛ - II**

Сорилын зөв хариулт

1-C, 2-E, 3-E, 4-B, 5-C, 6-D, 7-B, 8-C, 9-C, 10-C, 11-B, 12-A, 13-E, 14-A, 15-C, 16-D, 17-A, 18-C, 19-C, 20-E, 21-A, 22-C, 23-B, 24-C, 25-E, 26-A, 27-A, 28-B, 29-C, 30-A, 31-A, 32-A, 33-A, 34-C, 35-A, 36-C, 37-D, 38-E, 39-E, 40-C, 41-E, 42-C, 43-C, 44-E, 45-A, 46-B, 47-A, 48-D, 49-C, 50-C, 51-A, 52-E, 53-D, 54-A, 55-C, 56-C, 57-C, 58-C, 59-C, 60-C, 61-E, 62-B, 63-C, 64-C, 65-A, 66-A, 67-C, 68-C, 69-B, 70-A, 71-E, 72-A, 73-C, 74-B, 75-D, 76-B, 77-B, 78-A, 79-B, 80-A, 81-A, 82-A, 83-C, 84-A, 85-A, 86-A, 87-A, 88-D, 89-C, 90-C, 91-C, 92-C, 93-C, 94-A, 95-B, 96-A, 97-A, 98-B, 99-D, 100-B, 101-C, 102-E, 103-C, 104-A, 105-A, 106-C, 107-D, 108-E, 109-C, 110-D, 111-C, 112-D, 113-B, 114-B, 115-A, 116-C, 117-B, 118-A, 119-B, 120-D, 121-A, 122-A, 123-C, 124-D, 125-C, 126-A, 127-C, 128-E, 129-C, 130-A, 131-D, 132-C, 133-B, 134-B, 135-C, 136-A, 137-C, 138-B, 139-C, 140-B, 141-C, 142-C, 143-A, 144-B, 145-E, 146-E, 147-A, 148-A, 149-B, 150-B, 151-B, 152-B, 153-C, 154-A, 155-C, 156-B, 157-C, 158-C, 159-B, 160-A, 161-C, 162-D, 163-D, 164-B, 165-A, 166-C, 167-B, 168-E, 169-D, 170-A, 171-B, 172-A, 173-C, 174-B, 175-E, 176-C, 177-A, 178-C, 179-D, 180-D, 181-C, 182-C, 183-C, 184-D, 185-C, 186-A, 187-A, 188-C, 189-B, 190-A, 191-C, 192-C, 193-B, 194-C, 195-A, 196-A, 197-D, 198-C, 199-D, 200-A, 201-B, 202-A, 203-A, 204-D, 205-D, 206-E, 207-E, 208-D, 209-E, 210-C, 211-A, 212-C, 213-C, 214-E, 215-C, 216-C, 217-A, 218-E, 219-C, 220-D, 221-E, 222-A, 223-C, 224-A, 225-A, 226-B, 227-A, 228-C, 229-D, 230-C, 231-C, 232-B, 233-A, 234-A, 235-A, 236-A, 237-D, 238-D, 239-B, 240-C, 241-C, 242-C, 243-A, 244-A, 245-C, 246-E, 247-A, 248-A, 249-A, 250-A, 251-A, 252-D, 253-D, 254-C, 255-A, 256-A, 257-D, 258-D, 259-D, 260-C, 261-C, 262-D, 263-D, 264-D, 265-D, 266-D, 267-B, 268-C, 269-A, 270-D, 271-C, 272-B, 273-E, 274-A, 275-A, 276-A, 277-C, 278-C, 279-A, 280-C, 281-E, 282-E, 283-A, 284-A, 285-C, 286-A, 287-D, 288-D, 289-C, 290-C, 291-C, 292-D, 293-B, 294-D, 295-D, 296-B, 297-B, 298-A, 299-B, 300-A, 301-C, 302-C, 303-D, 304-A, 305-B, 306-A, 307-E, 308-A, 309-C, 310-D, 311-B, 312-A, 313-A, 314-B, 315-C, 316-E, 317-E, 318-A, 319-A, 320-E, 321-B, 322-B, 323-C, 324-E, 325-C, 326-D, 327-A, 328-E, 329-B, 330-A, 331-E, 332-D, 333-A, 334-C, 335-A, 336-C, 337-A, 338-C, 339-D, 340-B, 341-E, 342-E, 343-C, 344-A, 345-B, 346-B, 347-B, 348-A, 349-D, 350-E, 351-E, 352-A, 353-C, 354-A, 355-B, 356-B, 357-A, 358-C, 359-B, 360-C, 361-C, 362-E, 363-E, 364-C, 365-A, 366-A, 367-A, 368-A, 369-D, 370-B, 371-E, 372-B, 373-C, 374-A, 375-A, 376-D, 377-C,

Сорил хариулах заавар:

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох
1, 2, 3 дугаар хариултауд зөв бол (А.)

1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Шүдний ямар хэсэг эрдэсгүйжих процесст илүү өртөмтгий вэ?

1. таслах ирмэг

2. ховил

3. сурвалжийн хэсэг

4. хүзүү хэсэг

5. төвгөр

/2./ Цоорол үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүдийг сонгоно уу?

1. нүүрс ус

2. бактер

3. хатуу эдийн тэсвэрт чанар

4. цаг хугацаа

5. амны хөндийн эрүүл ахуй

/3./ Цоорлоос хамгаалах мэргэжлийн урьдчилан сэргийлэлтийн аргуудыг сонгоно уу?

1. силант тавих

2. мэргэжлийн цэвэрлэгээ

3. хувь хүнд тохирсон заавар, зөвөлгөө өгөх

4. хэсэг газарт фторын түрхлэг хийх

5. байнгын хяналтанд авах

/4./ Та дараах зүйлүүдийг хооронд нь уялдуулан сонгоно уу. А. шүд цоорох өвчний тархалтыг ямар томъёогоор олох вэ? В. цоорлын эрчмийг яаж тодорхойлох вэ? С. эмчлэх шаардлагатай нь хэдэн хувь байгааг яаж олдог вэ? D. холимог зуултын үеийн цоорлын эрчмийг ямар томъёогоор олох вэ? 1. $C+Л +A +ц +л$ үзсэн хүний тоо 2. $C+Л +A$ (шүдний тоо) бүгд үзсэн хүн 3. $(C+Л +A)$ шүдтэй хүний тоо $\times 100\%$ бүгд үзсэн хүн 4. Цоорсон шүдтэй хүний тоо $\times 100\%$ бүх өвчтэй хүний тоо

A. A4,B2,C4,D1

B. A3,B2, C4,D1

C. A4,B3,C1,D2

D. A2,B3,C1,D2

E. A1,B3,C2,D4

/5./ Борын эргэлтийн хурд ямар байхад хатуу эдийг өвдөлт багатай хэлбэржүүлэх вэ?

A. 200-300 мян. эр/хором

B. 80-100 мян. эр/хором

C. 300-600 мян.эр/хором

D. 20-40 мян. эр/хором

E. 50-90 мян. эр/хором

/6./ Цинк оксид эвгенол цементийг ямар ломбоны доор хэрэглэж болохгүй вэ?

A. амалгам

B. силикат

C. фосфат цемент

D. хуванцар

E. зоомол

/7./ Хүйтэн ариутгалаар юуг ариутгах вэ?

- A. өрөм, эндодонтын багаж, сэтгүүр, хямсаа, гладилка
- B. толь, иртэй багаж
- C. боолтын материал
- D. өрөм, толь, хямсаа, сэтгүүр
- E. бүх үзлэгийн багажийг ариутгана

/8./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх үндсэн зарчим нь юу вэ?

A. өвчингүй, иммуны бүсийг хүртэл урьдчилан сэргийлэх зорилгоор шүдний хатуу эдийг авах

- B. урьдчилан сэргийлэхээр авах ба биологийн бүтэн байдлын зарчим
- C. эрүүл эдээс аль болох бага авч эмгэг эдийг бүрэн авах
- D. паалан тугалмайн заагаас аль болох дээш өрөмдөх
- E. паалан тугалмайн заагийг аль болох давуулан өрөмдөх

/9./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх дараалал юу вэ?

A. өвчин намдаах, үхжсэн эдийг авах, өөлөх, хөндийг өргөсгөх
B. цоорлын хөндийг өргөсгөх, үхэжсэн эдийг авах, өөлөх
C. цоорлын хөндийг нээж өргөсгөөд үхжсэн эдийг авах, цоорлын хөндийг хэлбэржүүлэх, ирмэгийг дарах

- D. хөндийн ирмэгийг дарах, өвчин намдаах, цоорлын хөндийг өргөсгөх
- E. өвчин намдаах, цоорлын хөндийг хэлбэржүүлэх, ирмэгийг дарах, үхэжсэн эдийг авах

/10./ Паалангийн ирмэгийг ямар хүчил хэрэглэж сийрэгжүүлэх вэ?

- A. хүхрийн хүчил
- B. гурван хлорт цууны хүчил
- C. ортофосфорын хүчил
- D. азотын хүчил
- E. давсны хүчил

/11./ 24-р шүдний хөндийг ямар чиглэлд өргөсгөх вэ?

- A. урагшаа-хойшоо
- B. хацар-тагнайн
- C. тагнай талын гадарга
- D. уруул талын гадарга
- E. дээшээ доошоо

/12./ Сурвалжийн сувгийг ломбодоход юу хэрэглэдэг вэ?

- A. гуттаперч
- B. силидонт
- C. силикат
- D. силицин
- E. композит

/13./ Багаж ариутгах ямар аргууд байдаг вэ?

1. хуурай халуун
2. автоклав
3. буцалгах
4. хэт авиа
5. хүйтэн арга

/14./ I ангилалын цоорлыг ямар материалаар ломбодох вэ?

1. том дүүргэгчтэй хуванцар
2. холимог хуванцар
3. амальгам
4. фосфат цемент
5. цинкоксид эвгенол

/15./ II ангилалын цоорлыг ямар материалаар ломбодох вэ?

1. цинкоксид эвгенол
2. амальгам
3. фосфат цемент
4. холимог хуванцар
5. зоомол

/16./ III ангилалын цоорлыг ямар материалаар ломбодох вэ?

1. амальгам
2. иономерны цемент
3. фосфат цемент
4. хуванцар
5. поликарбоксилатны цемент

/17./ V ангилалын цоорлыг ямар материалаар ломбодох вэ?

1. хуванцар
2. глассиономер цемент
3. амальгам
4. фосфат цемент
5. цинкоксид эвгенол

/18./ Сувгийг яаж хуурайшуулах вэ?

1. файл
2. хөвөн трунд
3. суваг дүүргэгч
4. цаасан турунд
5. дрельбор

/19./ Гуттаперчийг нягтруулахдаа ямар багаж хэрэглэх вэ?

1. дрельбор
2. сувгийн сэтгүүр
3. сэтгүүр
4. хуруун спрэйдер
5. развертка

/20./ Гидроксид Са агуулсан сувгийн материалаар ямар суваг ломбодох вэ?

1. хэлбэржээгүй
2. шүүдэс ихтэй
3. шимэгдэж байгаа
4. сувгийн ханын цооролтой
5. сувгийн ханын шимэгдэлтэй

/21./ Та дараах зүйлүүдийг хооронд нь уялдуулан сонгоно уу. Цементийн ангилал Ломбоны материал А. цинк фосфат 1. Aquaionofil В. силикат 2. силидонт С. силикофосфат 3. силицин D. иономер 4. мөнгөлөг фосфат цемент 5. Fuji (IX) 6. инфантид 7. адгезор

- A. A4.7, B3, C2.6, D1.5
- B. A3.7, B2.4.1, C5, D6
- C. A4.1, B2.3.6, C5, D7
- D. A2.3, B7.1, C4.5, D6
- E. A1.4.7, B2.3, C6, D5

/22./ Эндодонтын багажийн ангилалыг нэрлэнэ үү. А. суваг цэвэрлэгч, өргөсгөгч В. сувгийн бусад багаж 1. сэтгүүр 2. зөөлц сугалагч 3. дрельбор 4. хямсаа 5. рашпиль 6. бурав 7. развертки 8. суваг дүүргэгч 9. хар зүү

- A. A2.8.9, B3.5.6.7
- B. A1.3.5.6, B2.8.9
- C. A3.5.6.7, B2.8.9
- D. A1.2.4.5, B3.6.7.8.9
- E. A3.5.6.7, B1.2.4.8.9

/23./ Сурвалжийн ломбоны ангилал Материал А. уян хатуурдаггүй материал 1. calciapex В. уян хатуурдаг материал 2. гуттаперч С. хатуу материал 3. caryoson normal 4. canason 5. metafex 6. фосфат цемент 7. штифт

- A. A1.7, B5.4, C3.6.2
- B. A1.5, B3.4.6, C2.7
- C. A1.2, B3.4, C5.6.7
- D. A1.3, B2.4, C5.6.7
- E. A2.4, B6.7, C1.3.5

/24./ Түр ломбоны материалыг зөөлцийн эмчилгээний үед шүдний хөндийг хаахад хэрэглэдэг. Учир нь түр ломбыг шууд зөөлц дээр тавьж болдог.

/25./ Бонд тавихын өмнө шүдийг сайтар хүчтэй үлээлгэж хуурайшуулах хэрэгтэй. Учир нь хүчил түрхсэний дараа үүсдэг гибрид давхрага нь ломбоны тогтоцыг сайжруулдаг.

/26./ Хүнцэлийг тун хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэвэл сурвалжийн оройн эдийг цочрооно. Тийм учраас 1% иодинолыг сувагт үлдээх нь үр дүн сайтай.

/27./ Амтлах булцуу агуулдаггүй хэлний хөхлөгийг нэрлэнэ үү?

- A. утаслаг
- B. мөөгөн
- C. навчин
- D. шигтгээн
- E. цэцгэн

/28./ Өвчтөний амны хөндийн эрүүл ахуйн төлөвийг ямар үзүүлэлтээр тодорхойлох вэ?

- A. ЦЛА
- B. Эрүүл ахуйн үзүүлэлт
- C. PMA
- D. CPITN
- E. Silness Loe

/29./ Дараах өвчнүүдийг ямар өвчнөөс ялгах вэ? А. цоорлын толбо В. зөөлцийн архаг үхжилтэт үрэвсэл С. буйлны улайлтат үрэвсэл D. ам гэмтэх E. сүүнцэртэл 1. гипоплази, флюорозын толбо 2. олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвсэл, сахуу, эмийн гаралтай стоматит 3. холбоосын архаг үрэвсэл 4. ам гэмтэх, сахуу 5. шүдний тулгуур эдийн үрэвсэл

- A. A1,B5,C2,D3,E4
- B. A1,B3,C4,D5,E2
- C. A1,B3,C5,D2,E4
- D. A2,B1,C4,D5,E3
- E. A3,B1,C4,D5,E2

/30./ Амны шингэний pH буурахад шүдний паалангийн гидроксиапатитын уусалт яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. багасдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. саармагждаг
- E. уусдаггүй

/31./ Ямар өвчнүүдийн үед паалангийн нэвчимтгий байдал нэмэгддэг вэ?

- A. шүд цоорох өвчний цагаан толбын үед
- B. шүд толботох өвчин
- C. гипоплази
- D. элэгдэл
- E. гиперплази

/32./ Ортофосфорын хүчлийн нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/33./ Сүүний хүчлийн нөлөөгөөр паалангийн нэвчимтгий байдал яаж өөрчлөгдөх вэ?

- A. нэмэгддэг
- B. буурдаг
- C. өөрчлөгддөггүй
- D. нэмэгдээд буурдаг
- E. буураад нэмэгддэг

/34./ Шүд цоорох өвчний үед өвдөлт ямар байх вэ?

- A. өөрөө аяндаа
- B. цочроогчийг арилгасны дараа өвдөх

- C. зөвхөн цочроогчийн нөлөөгөөр
 - D. шөнө өвдөлт өгнө
 - E. механик цочруулд өвдөнө
- /35./ Эрдэсжүүлэх эмчилгээнд хэрэглэгдэх бэлдмэлүүдийг сонгоно уу?
- 1. 10% кальц хлорид
 - 2. 1-3% ремодент
 - 3. Fluoridin
 - 4. кальцийн гидроксид
 - 5. сафорайд
- /36./ Өнгөц цоорлыг ямар өвчнүүдээс ялган оношлох вэ?
- 1. шүд толботох өвчний толбот хэлбэр
 - 2. шүдний паалангийн шархлаа
 - 3. цоорлын толбо
 - 4. шаантаг хэлбэрийн согог
 - 5. шүдний хатуу эдийн элэгдэл
- /37./ Тусгаарлах жийргэвчийг ямар зориулалтаар тавьдаг вэ?
- 1. зөөлцөд үүссэн цусны эргэлтийн хямралыг эмчлэх
 - 2. эмчилгээний жийргэвчийн үйлчлэлийг хадгалах
 - 3. дентинийг нөхөн төлжүүлэх
 - 4. байнгын ломбоны таагүй нөлөөнөөс зөөлцийг хамгаалах
 - 5. цоорлын хөндий гүн учраас
- /38./ Дунд цоорлын үед бодит үзлэгээр ямар шинж тэмдгүүд илрэх вэ ?
- 1. зөөлөрсөн тугалмайгаар дүүрсэн цоорлын хөндий
 - 2. цоорлын хөндийн ханаар мэдрэг
 - 3. тогшилтонд өвдөлтгүй
 - 4. зөөлцийн цахилгаан мэдрэг чанар 2-6 мкА
 - 5. рентген зурагт тугалмайн түвшинд хөндий үүссэн
- /39./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх дарааллуудыг сонгоно уу?
- 1. цоорлын хөндийг нээх
 - 2. цоорлын хөндийг өргөсгөх
 - 3. үхэжсэн эдийг авах
 - 4. хэлбэржүүлэх
 - 5. паалангийн хурц ирмэгийг дарах
- /40./ Паалангийн ирмэгийг ямар зорилгоор налуулан засдаг вэ ?
- 1. өөрчлөгдсөн пааланг бүрэн авах
 - 2. хоёрдогч цоорлоос сэргийлэх
 - 3. хазалтыг тааруулах
 - 4. ломбо паалангийн харьцах талбайг ихэсгэж ломбоны тогтоцыг сайжруулах
 - 5. цоорлын хөндийг томруулж ломбо тавихад хялбар болгох
- /41./ Шүд цоорох өвчин үүсэхэд нөлөөлөх хэсгийн хүчин зүйлүүдийг сонгоно уу?
- 1. амны хөндийн шингэний найрлага, шинж чанар
 - 2. нүүрс ус бүхий хоолны үлдэгдэл
 - 3. амны хөндийн эрүүл ахуй
 - 4. шүдний өнгөрийн бичил биетэнүүд
 - 5. шүдний байрлал
- /42./ Цоорлын цагаан толбын үеийг ямар өвчнүүдтэй ялган оношлох вэ?
- 1. паалангийн эрози
 - 2. шүд толботох өвчний толбын үе
 - 3. өнгөц цоорол
 - 4. гипоплазийн толбын үе
 - 5. шаантаг хэлбэрийн эмгэг
- /43./ Гүн цоорлын үед хөндийг хэлбэржүүлэх зарчмуудыг дурьдана уу.
- 1. цоорлын хөндийн ёроолын зөөлөрсөн тугалмайг үлдээнэ
 - 2. цоорлын хөндийн ёроолын хатуу, нөсөөжсөн тугалмайг үлдээнэ
 - 3. цоорлын хөндийн ёроолыг тэгшилнэ

4. тухайн шүдний анатомийн хэлбэрийн дагуу цоорлын хөндийн ёроолыг хэлбэржүүлнэ
 5. хөндийн хэлбэрээс хамаарч зөөлөрсөн эдийг авна
- /44./ Гүн цоорлын үед тавих эмчилгээний жийргэвчүүдийг сонгоно уу.
1. кальмецин
 2. calcicur
 3. dycal
 4. calcimol
 5. цинкоксид-эвгенолын цемент
- /45./ Цоорлын хөндийг хэлбэржүүлэх үед ямар алдаанууд гарах вэ?
1. хажуугийн шүдийг гэмтээх
 2. тугалмайн зөөлөрсөн хэсгийг дутуу авах
 3. шүдний хөндийг нээх
 4. шүдний зөөлцийг химийн бодисоор түлэх
 5. ломбонд хурц ирмэг гаргах
- /46./ Шүд цоорох өвчнүүдийн үед ямар эмчилгээг хийх вэ? А. цоорлын толбо 1. байнгын ломбо В. өнгөц цоорол 2. тусгаарлах жийргэвч, байнгын ломбо С. дунд цоорол 3. эрдэсжүүлэх D. гүн цоорол 4. эмчилгээний жийргэвч, тусгаарлах жийргэвч, байнгын ломбо
- A. A3,B2,C1,D4
 - B. A3,B1,C2,D4
 - C. A1,B2,C3,D4
 - D. A1,B3,C4,D2
 - E. A4,B2,C1,D3
- /47./ Дараах өвчний шинж тэмдгийг тохируулна уу А. гүн цоорол В. шаантаг хэлбэрийн согог С. өнгөц цоорол D. паалангийн шалбархай Е. архаг явцтай дунд цоорол 1. бүх цочролд мэдрэг 2. зовиургүй 3. бүх цочролд хоромхон зуур өвдөнө 4. исгэлэн зүйлд мэдэрнэ 5. шөнө өвдөнө
- A. A3,B1,C4,D,E2
 - B. A4,B1,C2,D5,E3
 - C. A5,B2,C4,D3,E1
 - D. A1,B2,C3,D5,E4
 - E. A1,B4,C1,D1,E2
- /48./ Цоорлын хөндий хэлбэржүүлэх үе шат А. цоорлын хөндий нээх В. цоорлын хөндий өргөсгөх С. үхжсэн эдийг авч ханыг хэлбэржүүлэх D. цоорлын хөндийн ёроолыг хэлбэржүүлэх Е. паалангийн ирмэгийг тэгшлэх Хэрэглэгдэх багажууд 1. бөөрөнхий өрөм 2. экскаватор, бортгон болон конусны өрөм 3. эсрэг конус хэлбэрийн өрөм 4. бортгон өрөм, конусны өрөм 5. бортгон өрөм, эмалийн багаж
- A. A1.4,B4,C2,D3,E5
 - B. A2,B1,C,D5,E1
 - C. A1,B2,C1,D4,E5
 - D. A1,B4,C2,D3,E5
 - E. A5.1,B4,C3,D1,E2
- /49./ Дунд цоорлын үед цоорлын хөндий тугалмайн зааг хэтэрсэн байдаг. Иймээс мэдрэлийн төгсгөл цочирч хоол ундны зүйл орохоор өвдөлт өгдөг.
- /50./ Дентиний давхарга нимгэрснээс цоорлын хөндийн ёроолоор их эмзэглэлтэй болдог. Иймд FC агуулсан бэлдмэл хэрэглэвэл хоёрдогч тугалмай үүсч эмзэглэл арилна.
- /51./ Блекийн 1- р ангилалын үед цоорлын хөндийг шүдний ховилын хэлбэрийг дагуулж хэлбэржүүлнэ. Учир нь цоорол шүдний төрөлхийн ховил хонхорт үүссэн байдаг.
- /52./ Өнгөц цоорол нь паалан тугалмайн зааг хүрсэн байдаг. Иймээс тусгаарлах жийргэвч тавьж ломбоддог.
- /53./ Гидрооксид кальци бүхий эмчилгээний жийргэвчийн хэрэглэх заалтыг нэрлэнэ үү.
1. зөөлцийн хурц тархмал үрэвсэл
 2. зөөлцийн үхжилт үрэвсэл
 3. зөөлцийн архаг томролтот үрэвсэл
 4. гүн цоорол
 5. дунд цоорол

/54./ Зөөлцийн хурц голомтот үрэвсэлтэй өвчтөнд илрэх шинж тэмдгүүдийг дурьдана уу.

1. зөөлөрсөн тугалмай бүхий цоорлын гүн хөндий
2. хөндийн ёроолоор сэтгүүрдэхэд 1 цэгт хүчтэй өвдөнө
3. хүйтэн зүйлд цочирч, удаан хугацаагаар өвдөнө
4. халуун хүйтэн цочроогчоос өвдөж, өвдөлт нь намдана
5. захын тунгалагийн булчирхайн үрэвсэл

/55./ Зөөлцийн үрэвслийн эмчилгээний үед сувгийг ямар түвшинд ломбодох вэ?

1. оройн нүхээр гартал
2. анатомын оройн нүх хүртэл
3. оройгоос 2,5 мм зайтай
4. физиологийн оройн нүх хүртэл
5. сувгийн 1/2 хүртэл

/56./ Гидроксид кальци бүхий эмчилгээний жийргэвчийг хэрэглэх заалтыг нэрлэнэ үү.

1. зөөлцийн хурц тархмал үрэвсэл
2. зөөлцийн хурц голомтот үрэвсэл
3. зөөлцийн архаг томролтот үрэвсэл
4. гүн цоорол
5. өнгөц цоорол

/57./ 1 сурвалжтай шүдний зөөлцийн хурц тархмал үрэвслийг эмчлэх аргыг сонгоно уу.

1. биологийн
2. зөөлцийг амьдаар нь бүрэн авах
3. зөөлцийг амьдаар нь тайрах
4. зөөлцийг үхжүүлж бүрэн авах
5. хавсарсан арга

/58./ Олон сурвалжтай шүдний зөөлцийн хурц тархмал үрэвслийг эмчлэх аргыг сонгоно уу.

1. биологийн
2. зөөлцийг амьдаар нь бүрэн авах
3. зөөлцийг амьдаар нь тайрах
4. зөөлцийг үхжүүлж бүрэн авах
5. зөөлцийг хадгалах

/59./ Доорхи өвчнүүдийг ямар өвчнөөс ялган оношлох вэ? А. зөөлцийн архаг ширхэглэг үрэвсэл В. зөөлцийн архаг үхжилт үрэвсэл С. зөөлцийн архаг томролтот үрэвсэл 1. гүн цоорол 2. зөөлцийн цочмог голомтот үрэвсэл 3. холбоосын архаг үрэвсэл 4. холбоосын цочмог үрэвсэл 5. шүдний хөндийн ёроолд перфораци болсоноос мөхлөнгөр эд ургах 6. хоншоорын хөндийн үрэвсэл 7. буйлны хөхлөгийн ургалт 8. холбоосын архаг үрэвслийн сэдрэл

- A. A2.4,B1.8,C5
- B. A3.6,B.8,C3
- C. A.2,B3,C5.7
- D. A8.3,B5.7,C8
- E. A5.7,B1.2.3,C48

/60./ Зөөлцийн цочмог тархмал үрэвслийн үед өвдөлт мэдрэлийн судлыг дагаж өвдөнө. Яагаад гэвэл арьсны мэдрэлийн төгсгөлүүд цочирсон.

/61./ Зөөлцийн архаг үхжилт үрэвслийн үед зөвхөн цөгцөн хэсгийн зөөлц үхжинэ. Иймд кальцийн гидроксид агуулсан эмчилгээний бэлдмэлийг шүдний хөндий нээгдсэн цэгт тавина.

/62./ Холбоосын үрэвслийн аль хэлбэрийн үед тогшилтонд хүчтэй өвдөлт өгөх вэ?

- A. холбоосын хурц үрэвслийн хордлогын үе
- B. холбоосын хурц үрэвслийн шүүдэст үе
- C. холбоосын архаг үрэвсэл
- D. холбоосны мөхлөнгөр үрэвсэл
- E. холбоосын сорвижилтот үрэвслийн үе

/63./ Ямар тохиолдолд холбоосын архаг үрэвслийг нэг удаагийн ирэлтээр эмчлэх вэ?

- A. холбоосын архаг ширхэглэг үрэвсэл
- B. холбоосын хурц үрэвсэл
- C. 1 сурвалжтай шүдний цорго үүссэн архаг мөхлөнгөрших үрэвсэл

- D. цорго үүссэн архаг мөхлөнгөрт үрэвсэл
E. сэдрэлийнх нь үед
- /64./ Ямар зорилгоор сувгийн эмчилгээнд уураг задлагч ферментүүдийг хэрэглэдэг вэ?
A. сурвалжийн оройд үүссэн үрэвслийг намжаах
B. сурвалжийн суваг дахь эмгэг төрөгч нянд үйлчлэх
C. зөөлцийн задралыг уусгах
D. зөөлцийг үхүүлэх
E. шүдний холбоосыг уусгах зорилгоор
- /65./ Холбоосын цочмог үрэвсэл ямар шалтгаанаас үүсч болох вэ?
1. гэмтэл
2. сурвалжийн сувагт болгоомжгүй ажилласнаас
3. архаг халдвар
4. шүдний чулуунаас
5. биеийн эсэргүүцэл муудсанаас
- /66./ Холбоосын цочмог үрэвслийн шүүдэст үед илрэх шинжийг тоочно уу.
1. байнга аяндаа өвдөнө
2. сурвалжийн орой орчмын шилжих нугалаасаар тэмтрэхэд өвдөнө
3. орчны тунгалагийн булчирхай томорно
4. шөнө өвдөнө
5. халуун, хүйтний цочроогчоос өвдөнө
- /67./ Шүдний сурвалжийн тахир сувгийг химийн аргаар өргөсгөхөд хэрэглэгдэх зүйлийг сонгоно уу.
1. 2,3 2-хлорт цууны хүчил
2. трилон-В (10-20%)
3. фторын уусмал
4. ЭДТА 20% усан уусмал
5. ортофосфорын хүчил
- /68./ Холбоосын архаг мөхлөнгөрших үрэвслийн эмнэлзүйн шинжмйг тоочно уу.
1. буйл хөндүүрлэж өвдөнө
2. буйланд цорго үүссэн
3. рентгенд өөрчлөлтгүй
4. сурвалжийн оройд цацраг хэлбэрийн бараан сүүдэртэй
5. сурвалжийн оройд тодорхой хил хязгаартай сүүдэртэй
- /69./ Холбоосын архаг мөхлөнгөрт үрэвслийн эмнэлзүйн шинжийг тоочно уу.
1. сурвалжийн оройд тодорхой хил хязгаартай сүүдэртэй
2. тогшилтонд бага зэрэг мэдрэг
3. тэмтрэхэд шүдний сурвалжийн оройн салст эмзэг
4. сэтгүүрт өвдөлтгүй
5. буйланд цорго үүссэн
- /70./ Холбоосын архаг ширхэглэг үрэвслийн эмнэлзүйн шинжийг тоочно уу.
1. сэтгүүр ба тогшилтод өвдөлтгүй
2. шүдний ойролцоох буйл, салст өөрчлөлтгүй
3. рентгенд шүдний холбоосын завсар нилдээ жигд өргөссөн
4. сурвалжийн оройд тодорхой хил хязгаартай сүүдэртэй”
5. сурвалжийн оройд цацраг хэлбэрийн бараан сүүдэртэй
- /71./ Шүдний холбоосын үрэвслийг эмчлэхэд баримтлах зарчим
1. макро, микро сувгуудыг сайн цэвэрлэж ариутгах
2. задарсан эд эсүүдийг бүрэн авах
3. үрэвсэл дарах
4. холбоост үүссэн өөрчлөлтийг арилгаж, нөхөн төлжилтийг сэргээх
5. бие махбодын хэт мэдрэгшлийг бууруулах
- /72./ Та дараах зүйлүүдийг хооронд нь уялдуулан сонгоно уу. Зовиур Өвчин А. үргэлжилсэн өвдөлт өгөх ба юм хазахад нэмэгдэнэ 1.зөөлцийн архаг ширхэглэг үрэвсэл В. байнгын өвдөлт өгөх ба шүд сунасан мэт санагдана 2.холбоосын хурц үрэвслийн хордлогын үе С. нүүрний тэгш хэм алдагдсан, шүдний орчим өвдөлтгүй 3.холбоосын хурц үрэвслийн шүүдэст

үе 4.зөөлцийн архаг үхжилт үрэвсэл 5. ясны хальсны үрэвсэл салстын доорхи буглаатай хавсрах

- A. A2,B3,C5
- B. A3,B2,C5
- C. A5,B2,C4
- D. A2,B4,C5
- E. A4,B2,C1

/73./ Холбоосын үрэвсэл А. холбоосын цочмог үрэвсэл В. архаг ширхэглэг үрэвсэл С. архаг мөхлөнгөрших үрэвсэл D. архаг мөхлөнгөрт үрэвсэл E. архаг үрэвслийн сэдрэл Рентген зурагт гарах өөрчлөлт 1. сурвалжийн оройд тодорхой хил хязгаартай сүүдэр 2. ясны сийрэгжилт 3. сурвалжийн оройд тодорхой хил хязгааргүй сүүдэр ясны эдийн сийрэгжилтийн голомт 4. холбоосын завсар өргөссөн байна 5. холбоосын архаг үрэвслүүдийн аль нэг хэлбэрийн өөрчлөлт харагдана

- A. A4,B2,C3,D1,E5
- B. A4,B3,C1,D2,E5
- C. A2,B4,C3,D1,E5
- D. A1,B2,C4,D3,E5
- E. A4,B2,C1,D3,E5

/74./ Шүдний холбоос А. эрүүний шүдэнд В. хоншоорын шүдэнд С. шүдлэж гүйцээгүй, эсрэг талын хорших шүдгүй шүдэнд 1. 0.05-0.15мм 2. 0.15-0.22 мм 3. 0.20-0.25 4. 1-2 мм 5. 2-3 мм

- A. A1.2,B3,C4.5
- B. A2,B3,C1
- C. A2,B4,C5
- D. A2,B4,C1
- E. A,B3,C4

/75./ Холбоосын архаг мөхлөнгөрших үрэвслийн эмчилгээний үед эхний ирэлтийн дараа заавал онгорхой орхино. Яагаад гэвэл холбоосны архаг мөхлөнгөрших үрэвсэл нь удаан хугацааны туршид байгаа холбоосын архаг үрэвсэл юм.

/76./ Ундны усан дахь фторын хэмжээ хэд болоход шүд толботох өвчин үүсэх вэ?

- A. 1 мг/л
- B. 1.5 мг/л-ээс дээш
- C. 2 мг/л
- D. 4 мг/л
- E. 0.8 мг/л

/77./ Шүд толботох өвчний толбот хэлбэрийн эмчилгээг тоочно уу.

- A. хуванцар ломбоор сэргээх
- B. цайруулах ба эрдэсжүүлэх эмчилгээ
- C. фтортлак түрхэх
- D. шүдийг авах
- E. содтой усаар зайлуулах

/78./ Шүд толботох өвчний үед зөвхөн 1шүд гэмтэх тохиолдол байх уу?

- A. үгүй
- B. байж болно
- C. өвчний хэлбэрээс хамаарна
- D. өвчний явцаас хамаарна
- E. фторын агууламжаас хамаарна

/79./ Шүдний эмгэг элэгдлийн үед паалан ба тугалмайн гэмтэл хаана байрлах вэ?

- A. үүдэвчийн гадарга ба таслах ирмэг
- B. таслах ирмэг ба зажлах гадарга
- C. зажлах ба хэлэн гадарга
- D. хэлэн ба үүдэвчийн гадарга
- E. шүдний бүх гадарга

/80./ Хатуу эдийн шалбархайн эмнэл зүйн шинж тэмдэгийг тоочно уу.

- A. ёроол нь толигор хатуу, зууван дугуй хэлбэртэй
- B. ёроол нь зөөлөн, нэг цэгт өвдөлттэй

- С. цөгцний үүдэвчийн гадаргад олон тооны толботой
- D. шүдний хүзүүгээр цэхэр зураасуудтай, паалан барзгар хөвсгөр
- Е. шүдний хүзүүгээр буйл паалангийн гэсэн 2 гадаргатай хатуу эдийн эмгэгтэй, паалан тугалмай хатуу

/81./ Шаантаг хэлбэрийн согоогоос яаж урьдчилан сэргийлэх вэ?

- 1. фтортой шахмал эм хэрэглэх
- 2. зөөлөн үстэй сойз хэрэглэх
- 3. хүчиллэг зүйл хэрэглэхийг хязгаарлах
- 4. фтортой оо хэрэглэх
- 5. амыг шүлтлэг уусмалаар зайлуулах

/82./ Ямар хүнсний бүтээгдэхүүнд фтор ихээр агуулагдаж байдаг вэ?

- 1. өндөгний шар
- 2. далайн загас
- 3. махан бүтээгдэхүүн
- 4. талх
- 5. элсэн чихэр

/83./ Шүдний уутанцарын мезенхимээс юу юу үүсэх вэ?

- 1. тугалмай
- 2. холбоос эд
- 3. зөөлц
- 4. ясжмаг эд
- 5. паалан

/84./ Халдварын гаралтай холбоосын цочмог үрэвслийн шалтгааныг нэрлэнэ үү.

- A. зөөлцийн цочмог тархмал үрэвсэл
- B. шүдний гэмтэл
- C. өнгөц цоорол
- D. шүд цоорох өвчний дунд үе
- E. цоорлын бус гаралтай шүдний хатуу эдийн эмгэгүүд

/85./ Холбоосын цочмог хордлогот үрэвслийн эмнэл зүйн шинжийг дурьдана уу.

- A. шүдээр юм хазахад өвдөнө
- B. нүүрний зөөлөн эдийн хаван
- C. буйлан дээрхи идээт цорго
- D. хэл хавдаж хавагнасан
- E. хоол залгихад хөндүүртэй

/86./ Холбоосын архаг мөхлөнгөрших үрэвслийн үеийн рентген зурагт гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү.

- A. тодорхой хил хязгааргүй, янз бүрийн хэмжээтэй ясны эдийн сийрэгжилтын голомт
- B. тодорхой хил хязгаартай, 5 мм хүртэл хэмжээтэй дугуй ба зууван хэлбэртэй ясны эдийн сийрэгжилтийн голомт
- C. шүдний сурвалжийн орой хэсгийн холбоосын завсар өргөссөн
- D. тодорхой хил хязгаартай, 1 см-с дээш хэмжээтэй дугуй ба зууван хэлбэртэй ясны эдийн сийрэгжилтийн голомт
- E. рентген зурагт ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

/87./ Цөгцний хугарал гэж юу вэ?

- 1. паалангийн хэсэг хугарах
- 2. тугалмайн түвшинд цөгцний хэсэг хугарах (зөөлц ил гарсан ба гараагүй)
- 3. шүдний хүзүүний түвшинд цөгц хугарах
- 4. буйлны ховилоос доогуур хугарах
- 5. шүдний ясжмаг эдийн түвшинд хугарах

/88./ Амны салстын архаг дахилтат шархлаат үрэвслийн гол шинжүүдийг нэрлэнэ үү.

- 1. уруулын улаан дээр олон тооны цэврүүт тууралт
- 2. буйлны хурц улайлтат үрэвсэл
- 3. амны салстын янз бүрийн хэсэгт цэврүү
- 4. дугуй эсвэл зууван хэлбэртэй шалбархай
- 5. улайсан суурь бүхий хурц ирмэгтэй төрөл бүрийн хэлбэрийн шалбархай

/89./ Амны салстын өвдөлтийг намдаахад ямар бэлдмэл хэрэглэх вэ?

1. 1% новокайны уусмал
2. 10% лидокайны спрей
3. 0,1% анестезинтэй тос
4. 10% анестезинтэй тос
5. 5% анестезинтэй тос ба глицериний хольц

/90./ Нөхөн төлжүүлэх үйлчлэлтэй бэлдмэлүүдийг нэрлэнэ үү.

1. теброфеновын тос
2. нохойн хошуу
3. неомицины тос
4. чацарганы тос
5. канестен (клотримазол)-н тос

/91./ Эрүүл буйлны ховил юуг өөртөө агуулах вэ?

- A. цус
- B. шингэн
- C. буйлны шингэн
- D. мөхлөнгөр эд
- E. шүлс

/92./ ШТЭ-ийн хатингаршил нь ямар өвчин бэ?

- A. үрэвсэлт
- B. үрэвсэл-тэжээлийн дутагдлаас үүссэн
- C. тэжээлийн дутагдлаас
- D. хавдрын улмаас үүссэн
- E. удамшлын өвчин

/93./ Буйлны үрэвслийн үед эрт илрэх шинж тэмдэг нь юу вэ?

- A. буйлны хөхлөгийн хэлбэр алдагдах
- B. буйл шүдний эмгэг хөндийн гүн 3 мм
- C. сэтгүүрдэхэд буйлнаас цус гарах
- D. буйл хатингарших
- E. буйлнаас аяндаа цус гарах

/94./ Буйлны улайлтат үрэвсэл ямар өвчин вэ?

- A. үрэвсэлт
- B. тэжээлийн дутагдлаас үүссэн
- C. үрэвсэл - тэжээлийн дутагдлаас үүссэн
- D. удамшлын
- E. төрөлхийн

/95./ Буйлны шархлаат үхжилт үрэвслийн үед ямар бичил биетэн зонхилох вэ?

- A. стафилококк, спирохетүүд
- B. спирохетүүд, фузобактерүүд
- C. фузобактерүүд, лактобациккүүд
- D. мөөгөнцрүүд
- E. алтлаг стафилококк

/96./ Буйлны улайлтат үрэвслийн ялгах онош юу вэ?

- A. ШТЭҮӨ
- B. фиброматоз
- C. ШТЭ хатингаршил
- D. герпетический гингивостоматит
- E. эпулис

/97./ Буйл- шүдний хуурамч эмгэг хөндий хаана үүсэх вэ?

- A. буйл
- B. буйл ба холбоос
- C. буйл, холбоос, түүшин яс
- D. буйл, түүшин яс
- E. түүшин яс

/98./ ШТЭҮӨ-ний хөнгөн хэлбэрийн үед түүш хоорондын таславчийн шимэгдэлт рентген зурагт ямар байх вэ?

- A. өөрчлөлтгүй
- B. 1/3 нь шимэгдсэн
- C. 1 /2 нь шимэгдсэн
- D. 2/3 нь шимэгдсэн
- E. 1/4 шимэгдсэн

/99./ ШТЭҮӨ-ний хүнд хэлбэрийн үед түүш хоорондын таславчийн шимэгдэлт рентген зурагт ямар байх вэ?

- A. өөрчлөлтгүй
- B. 1/3 нь шимэгдсэн
- C. 1 /2 нь шимэгдсэн
- D. 2/3 нь шимэгдсэн
- E. 1/4 шимэгдсэн

/100./ Буйл шүдний эмгэг хөндийн гүн 4-6 мм үед юү хийх вэ?

- A. кюретаж
- B. нээлттэй кюретаж
- C. лоскутны хагалгаа
- D. эмийн эмчилгээ
- E. ажиглах

/101./ Буйлны улайлтат архаг тархмал үрэвсэл үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү.

- 1. судасны эсрэг бэлдмэлүүд хэрэглэх
- 2. амны хөндийн эрүүл ахуйг муу сахих
- 3. архаг гэмтэл
- 4. аминдэм С-ийн дутагдал
- 5. аминдэм А-ийн дутагдал

/102./ Буйлны улайлтат архаг үрэвслийн эмнэл зүйн шинж тэмдэгийг дурьдана уу.

- 1. сэтгүүрдэхэд буйлнаас цус гарах
- 2. буйл хөхөлбөр өнгөтэй
- 3. шүдэнд өнгөр үүсэх
- 4. буйлан дээр чулуутай
- 5. буйлан доор чулуутай

/103./ Буйлны шархлаат үхжилт үрэвслийн эмнэл зүйн шинж тэмдэгийг дурьдана уу.

- 1. буйл томорч ургах
- 2. шүдний өнгөр ихсэх
- 3. буйлны ирмэг хөхрөх
- 4. буйлны хөхлөг үхжих
- 5. буйл хатингарших

/104./ ШТЭ-ийн архаг үрэвслийн хөнгөн хэлбэрийн үед илрэх өөрчлөлтийг сонгоно уу.

- 1. 3-4мм хүртэл гүнтэй буйл шүдний эмгэг хөндий үүсэх
- 2. буйлан дээр чулуутай
- 3. буйл хөхрөх
- 4. шүдний сурвалж ба хүзүүвч ил гарах
- 5. буйл улайх

/105./ Өнгөрийг төгс цэвэрлэх нь тулгуур эдийн өвчний эмчилгээний чухал хэсэг. Учир нь өнгөрийг цэвэрлэснээр шүдний чулуу үүсэх нь саатна.

/106./ Ямар процессын үед эс хоорондын холбоос хайлснаас өргөст давхаргын эсүүдэд дегенератив өөрчлөлт гарах вэ?

- A. спонгиоз
- B. акантоз
- C. акантолиз
- D. паракератоз
- E. папиломатоз

/107./ Мөөгөнцөрийн эсрэг бэлдмэлүүдийг нэрлэнэ үү.

- A. диазолин ба оксациллин

- В. оксациллин ба метронидазол
 - С. метронидазол ба нистатин
 - Д. нистатин ба леворин
 - Е. амоксациллин ба метронидазол
- /108./ Олон хэлбэрт шүүдэст улайлтат үрэвслийн хүнд хэлбэрийг нэрлэнэ үү.
- А. Бехчетын хам шинж
 - В. Сеттоны афт
 - С. Шегрены хам шинж
 - Д. Розенталийн хам шинж
 - Е. Стивенс-Джонсоны хам шинж
- /109./ Могой ярын үүсгэгчийг сонгоно уу.
- А. фузоспирохетүүд
 - В. энгийн герпесын вирус
 - С. салхин цэцгийн вирус
 - Д. коксакийн вирус
 - Е. гриппын вирус
- /110./ Вирозол, Бонафтон, Зовиракс бэлдмэлийн үйлчилгээг тоочно уу.
- А. үрэвслийн эсрэг
 - В. десенсблизирующий
 - С. аминдэм
 - Д. вирусын эсрэг
 - Е. халуун бууруулах
- /111./ Хоёрдогч морфологи элементүүдийг нэрлэнэ үү.
- 1. толбо
 - 2. тав
 - 3. киста
 - 4. шархлаа
 - 5. цэврүүнцэр
- /112./ Хомхой долоох өвчний үед амны хөндийн салстан дээр олон тооны цэврүүнүүд гарна. Иймд ялган оношлохдоо цэврүүнээс авсан эсийн шинжилгээгээр онош тогтооно.
- /113./ Харшилын тодорхойлолтыг сонгоно уу.
- А. аливаа бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
 - В. антиген ба гаптен шинжтэй бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
 - С. антиген ба гаптен шинжтэй бодист бие махбод мэдрэгших урвал
 - Д. антиген бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
 - Е. гаптен шинжтэй бодист бие махбод өвөрмөц хэт мэдрэгших урвал
- /114./ Анафилакси шокын дараа үүсдэг антианафилакси механизм юугаар нөхцөлддөг вэ?
- А. реакин
 - В. хориг эсрэг бие
 - С. үл тунадасжигч эсрэг бие
 - Д. биеийн эд эс үхжих
 - Е. цусан хангамжийн дутагдал
- /115./ Анафилакси шокын үед хожуу гардаг, өвчтөнийг үхэлд хүргэж болох хүндрэлийг нэрлэнэ үү.
- 1. харшлын миокардит
 - 2. харшлын гломерулонефрит
 - 3. харшлын гепатит
 - 4. харшлын ринит
 - 5. чонон хөрвөс
- /116./ Зөөлцийн хурц голомтот үрэвсэл ямар хугацаанд үргэлжлэх вэ?
- А. 10 хоног
 - В. 12 хоног
 - С. 2 хоног
 - Д. 14 хоног
 - Е. 7 хоног

/117./ Зөөлцийн хурц тархмал үрэвслийн үед цоорлын хөндийн хаана сэтгүүрдэхэд хүчтэй өвдөх вэ?

- A. 1 цэгт (цоорлын хөндийн ёроолд)
- B. цоорлын хөндийн ёроолоор
- C. паалан-тугалмайн заагаар
- D. огт өвдөхгүй
- E. цоорлын хөндийн ханаар

/118./ Зөөлцийн хурц үрэвслүүдийн үед халуун, хүйтний сорилд яах вэ?

- A. хүчтэй өвдөнө
- B. өвдөнө
- C. өвдөхгүй
- D. цочроогчийг авахад өвдөлт намдана
- E. сулхан нэгэн хэвийн өвдөлт өгнө

/119./ Шүдний эмчийн мэргэжлийн ур чадвар төлөвшиж тогтох үе

- A. 1-10 жил
- B. 10-15 жил
- C. 5-10 жил
- D. 3- 10 жил
- E. 4-10 жил

/120./ Шүдний эмнэлгийн гарцад юу юу багтах вэ?

- 1. Хүний нөөцийг зөв ашиглах
- 2. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд эмнэлэг үйлчилгээ явуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх процесс
- 3. Маркетингийн ш/у-ны орц гарцыг дайчлан ашиглаж капитал үйлдвэрлэх арга
- 4. Өвчтөнүүдэд дээд зэргийн чанартай тусламжийг үзүүлж чанарт тохирсон үнийг бүрдүүлж ашиг орлого олох
- 5. Технологийн нөөцийг зөв ашиглах

/121./ Өртөг гэж юу вэ?

- 1. Орцыг гарц болгох арга
- 2. Эмнэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход зарцуулсан байх нөөцийн тооцоо
- 3. Шууд ба шууд бус зардлыг нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцааны илэрхийлэл
- 4. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шууд бус зардалд харьцуулсан харьцааны илэрхийлэл
- 5. Гарцыг орц болгох арга

/122./ Шүдэлбэрийн дизайныг төлөвлөхдөө буйлны ирмэг ба их холбогчийн хоорондын зай хэд байх вэ?

- A. 4 mm
- B. 2 mm
- C. 3 mm
- D. 5 mm
- E. 1 mm

/123./ Шахмал шүдэлбэрийн зохиомж зурахын өмнө ажлын загвар дээр дараах үйлдлүүдийг хийнэ

- 1. Маржинг тодорхойлно
- 2. Суурийг өөлж засна
- 3. Шүдний хүзүүвчийг тодруулна
- 4. Усанд норгоно
- 5. Шүд бүрийг өөлнө

/124./ Ажлын загвар дээр хорших дэрлэгтэй суурь бэлтгэхийн өмнө дараах үйлдлийг хийнэ

- 1. Маржинг тодорхойлно
- 2. Суурийг өөлж засна
- 3. Шүдний хүзүүвчийг тодруулна
- 4. Усанд норгоно
- 5. Шүд бүрийг өөлнө

/125./ Шүд түүшийн хатингаршлын хэдэн түвшин байдаг вэ?

- A. 2
- B. 3
- C. 4
- D. 5
- E. 6

/126./ Шүд түүшийн тусгал бичлэг гэж юу вэ?

- A. Шүдний тулгуур эдийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
- B. Амны салст бүрхүүлийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
- C. Ам ангайх түвшинг тооцон хүснэгтэд буулгах
- D. Амны бүрхүүлийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах
- E. Шүдний эдийн байдлыг тооцон хүснэгтэд буулгах

/127./ Онош гэж юу вэ?

- A. Эмч нарын онол туршлагын үр дүнд хийж буй оюун ухааны үйлдэл
- B. Эмч нарын эмнэлзүйн сэтгэлгээний үр дүнд өвчний мөн чанарын тухай хийж буй оюун ухааны дүгнэлт
- C. Эмч нарын эмнэлзүйн сэтгэлгээний үр дүнд өвчний мөн чанарын тухай өвчний нэр томъёог ашиглан бичсэн оюун ухааны дүгнэлт
- D. Эмч нарын эмнэлзүйн үр дүнд өвчний мөн чанарын тухай хийж буй оюун ухааны дүгнэлт
- E. Эмч нарын өвчний мөн чанарын тухай өвчний нэр томъёог ашиглан бичсэн оюун ухааны дүгнэлт

/128./ Шүд түүшийн тусгал бичлэгт эрүүний түүшийн хатингаршлыг Келлер хэд ангилсан бэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 0
- E. 4

/129./ Шүд түүшийн тусгал бичлэгт хоншоорын түүшийн хатингаршлыг Шредер хэд ангилсан бэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 0
- E. 4

/130./ Шүдний хоршилтын мөрийг ямар ямар аргаар тодорхойлдог вэ?

- 1. Үзлэгээр
- 2. Загвар шинжилгээгээр
- 3. Окклюдзиограммын аргаар
- 4. Асуумжаар
- 5. Багажаар

/131./ Шүдний эгнээний урд хэсгийн согог Кеннедийн хэддүгээр ангилалд хамаарах вэ?

- A. I
- B. II
- C. III
- D. IV
- E. V

/132./ Нэг талын хөвөөлсөн шүдтэй шүдний эгнээний согог Кеннедийн хэддүгээр ангилалд хамаарах вэ?

- A. I
- B. II
- C. III
- D. IV
- E. V

/133./ Оксманы шүдэлбэр болон нүүр амны хиймэл эрхтнийг ангилсан ангилал аль нь вэ?

- 1. Шүдний цөгцний согогийг орлосон хэлбэр

2. Шүдний эгнээний согогийг орлосон шүдэлбэр
 3. Шүдгүй эрүү хоншоорт зориулсан шүдэлбэр
 4. Эрүү нүүрний хиймэл эрхтэн
 5. Шүдтэй эрүү шүдгүй хоншоорт зориулсан шүдэлбэр
- /134./ Шүд засч бэлтгэхэд ямар ямар мэдээгүйжүүлэлтийн арга хэрэглэх вэ?
1. Түрхэж шүршиж мэдээгүйжүүлэх
 2. Тарьж мэдээгүйжүүлэх
 3. Эм уулган мэдээгүйжүүлэх
 4. Дуу авиагаар
 5. Шүдийг засах
- /135./ Бэлэн болсон бүрээсэнд тавигдах шаардлага.
1. Хоршилтыг бага зэрэг өндөрсгөж болно
 2. Хажуу шүдтэйгээ ямарч зай завсаргүй түшилцэх
 3. Шүдний цөгцний анатомийг бүрэн сэргээгээгүй байж болно
 4. Зажлах үйлийг сэргээсэн байх
 5. Хажуу шүдтэйгээ түшилцээгүй байж болно
- /136./ Голомцын төрлийг сонгоно уу?
1. Стандарт
 2. Индивидуаль
 3. Цутгамал
 4. Шилэн ширхэгт
 5. Гуттаперч
- /137./ Дэгээ нь ямар эд ангиудаас бүрдэх вэ?
- A. Мөр,бие,хумс
 - B. Мөр,сүүл,хоршихуйн даравч
 - C. Мөр,бие,хумс,сүүл,хоршихуйн даравч
 - D. Мөр,бие, хоршихуйн даравч
 - E. Мөр,хумс,сүүл,хоршихуйн даравч
- /138./ Шүдний цөгцийг бүслэж байгаа пүршлэг хэсгийг нэрлэнэ үү?.
- A. Дэгээний хумс
 - B. Дэгээний мөр
 - C. Дэгээний бие
 - D. Дэгээний сүүл
 - E. Дэгээний үзүүр
- /139./ Дэгээний сүүл хаана байрлах вэ?
- A. Сүүлийг шүдэлбэрийн суурийн тагнай талд
 - B. Сүүлийг шүдэлбэрийн суурийн хэл талд
 - C. Сүүлийг хиймэл шүдэн дор байх шүдгүй түүшийн ирмэгийн дагуу
 - D. Сүүлийг хиймэл шүдэн дор түүшийн ирмэгийн дагуу
 - E. Сүүлийг шүдгүй түүшийн ирмэгийн чиглэлийн дагуу
- /140./ Дэгээг шүдэлбэрийн суурьтай холбох ямар аргууд байдаг вэ?
- A. Тогтвортой,тогтворгүй
 - B. Хатуу,пүршлэг,үений
 - C. Хагас тогтвортой,тогтворгүй
 - D. Хатуу,үений
 - E. Хатуу,пүршлэг,үений суурийн
- /141./ Хүүхдийн шүдний эгнээний согог юунаас болж үүсдэг вэ ?
1. Шүд унах
 2. Шүд хорхойтох
 3. Хорших гадаргуугын хоёрдогч гажуудал
 4. Анхдагч шүдгүйтэл
 5. Шүд сулрах
- /142./ Шүдэлбэрийн урьдал хийцийг эмнэл зүйн хэдэн аргаар шалгах вэ?
- A. 1
 - B. 4

C. 2

D. 8

E. 5

/143./ Шүдний тойрон эдийн үйлийн хэт ачаалал хэдийд үүсэх вэ ?

A. Зарим шүд унасан, захилах байрлал өөрчилөгдсөн

B. Хоршилтын гажиг үүссэн

C. Авагддаг ба авагддаггүй шүдэлбэр буруу хийгдсэн

D. Авагддаггүй шүдэлбэр буруу хийгдсэн

E. Зарим шүд унасан, байрлал өөрчилөгдсөн

/144./ Зуултын өндөрийг зөв тодорхойлсон эсэхийг яаж шалгах вэ ?

A. Рентген зураг

B. Нүүрэн дээрх хэмжил зүйн аргаар

C. Амны хөндийн дотоод үзлэг

D. Дэлгэмэл зураг

E. Ерөнхий үзлэг

/145./ Хиймэд шүд өрөхөд юуг анхаарах вэ ?

1. Шүдний нум

2. Шүдний нумны дагуу муруй

3. Шүдний нумны хөндлөн муруй

4. Түүшин сэртэнгийн ирмэг

5. Үлдсэн шүдний босоо тэнхлэг

/146./ Шүдэлбэр зүүсний эхний хэд хоногт өвчтөнд ямар зовиур илрэх вэ?

1. Огиудас хүрэх

2. Шүлс асгарах

3. Хоолны амтыг муу мэдрэх

4. Авиа бүдэгших

5. Хуванцар амтагдах

/147./ Уруул тагнайн төрөлхийн согогийн монголд тохиолдох тохиолдол?

A. 1341 төрөлтөд 1

B. 1000 төрөлтөд 1

C. 1000 төрөлтөд 3

D. 1341 төрөлтөд 2

E. 1321 төрөлтөд 3

/148./ Бүрэн шүдгүйдлийн үед анатоми-физиологийн аргаар юуг тодорхойлдог вэ?

A. Зуултын өндөр

B. Эмнэл зүйн өндөр

C. Нүүрний өндөр

D. Хамрын өндөр

E. Хоршилтын өндөр

/149./ Зуултын өндөр болон голлосон хоршилтыг тодорхойлохдоо:

1. Суурь дэрлэгийн тэгш хэмийг тодорхойлох

2. Үүдэвчийн нумын хэлбэрийг тодорхойлох

3. Эрүү хоншоорын хорших харьцааны өндөрийг тодорхойлох

4. голлосон хоршилтыг тодорхойлох

5. “эрүүний үений байрлалыг 2 талдаа тодорхойлох

/150./ Н.Пүрэвжавын “эрүүнд зориулсан сорилууд аль нь вэ?

1. Хэлээ баруун зүүн тийш хэд хэдэн удаа хөдөлгөнө

2. Хацарын дотор салстыг долоох маягийн хөдөлгөөн

3. Уруулаа цорвойлгож эргүүлэн хэвийн болгох

4. Хацараа дотогш хонхойлгон сорох хөдөлгөөн хийх

5. Үсэг хэлүүлэн дуудуулах

/151./ А.Я.Катцын тодорхойлсноор үелэхүй гэж юуг хэлэх вэ?

A. Бүх шүдний эгнээ баруун талдаа их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн

B. Бүх шүднүүд бүх чиглэлээр харьцаж байрлал хөдөлгөөн

С. Бүх шүдний эгнээ зүүн талдаа их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн

D. Бүх шүднүүд урагшаа,арагшаа харьцах байрлал хөдөлгөөн

Е. Бүх шүдний эгнээ их бага ямар нэг хугацаагаар хоорондоо харьцах байрлал хөдөлгөөн
/152./ Үений хажуу замын өнцөг дунджаар хэдэн градус байдаг вэ?

A. 18 градус

B. 17 градус

C. 16 градус

D. 15 градус

E. 14 градус

/153./ Үүдэн шүдний хөндлөн замын өнцөг буюу Шот-ын өнцгийн утга хэд вэ?

A. 40-50 градус

B. 17-27 градус

C. 100-110 градус

D. 45-55 градус

E. 35-45 градус

/154./ Дараах хоршилтын шинжүүдээс үүдэн шүдэнд хамаарах шинжийг хэлнэ үү?

A. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 хавтгайд байрлана

B. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

C. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

D. Дээд шүд бүр нь доод талын адил нэртэй шүд болон түүний ар талд оршиж байгаа шүдтэй хавсарч хоршино

E. Хоншоор болон эрүүний шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 хавтгайд байрлана

/155./ Дараах хоршилтын шинжүүдээс араа шүдний дагуу чиглэлд хамаарах шинжийг хэлнэ үү?

A. Хоншоор болон эрүүний голын үүдэн шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

B. Дээд шүдний тагнайн төвгөр доод шүдний тууш ховилд, доод талын шүдний хацрын төвгөр дээд шүдний тууш ховилд сууна

C. Дээд талын I арааны хацрын ар талын төвгөр доод талын ийм нэртэй арааны хацрын ар төвгөр болон доод талын II арааны хацрын урд төвгөр 2-н дунд байрлана

D. Дээд шүд бүр нь доод талын адил нэртэй шүд болон түүний ар талд оршиж байгаа шүдтэй хавсарч хоршино

E. Хоншоор болон эрүүний шүднүүдийн дундуур өнгөрч байгаа дунд шугам 1 дагуу хавтгайд байрлана

/156./ Муруй зуултын үед үүдэн шүднүүд хэвийн хорших уу?

A. Хоршино

B. Хоршихгүй

C. Хэвийн

D. Зөрж хоршино

E. Давж хоршино

/157./ Эмнэл зүйн цөгц гэж юу вэ?

A. Шүдний эмтэрсэн хэсэг

B. Шүдний төвгөр

C. Шүдний буйлнаас дээш гарсан хэсэг

D. Паалангаар хучигдсан шүдний хэсэг

E. Шүдний ёзоор

/158./ Энглийн 1-р ангиллын зуултын үед хамар уруулын нугалаас ямар байх вэ?

A. Тэнийнэ

B. Гүнзгийрнэ

C. Хэвийн

D. Уртасна

/159./ Хам орсгой зуултын онцлог шинжийг сонгоно уу

- A. Дээд доод үүдэн шүднүүд дотогш налсан зуулт
- B. Дээд доод үүдэн шүднүүд гадагш орсойсон зуулт
- C. Үүдэн шүднүүд зөрсөн
- D. Үүдэн шүднүүд ирмэгээрээ хоршисон
- E. Үүдэн шүднүүд заалхайтсан

/160./ Байнгын шүдний зуултыг юу тодорхойлдог вэ?

- A. Шүдний тоо
- B. Шүдний эгнээний хэлбэр
- C. Эрүүний хэмжээ
- D. Шүдний эгнээний нийлэх байдал, харьцаа
- E. Зуултын өндөр

/161./ Физиологийн зуултанд дараах орно

- A. Ортогнатик, шулуун, заалхай
- B. Ортогнатик, шаамий, орсгой, шулуун
- C. Ортогнатик, бипрогнатик, шулуун
- D. Ортогнатик, шаамий, орсгой
- E. Зөвхөн ортогнатик зуулт

/162./ Босоо чиглэлээр үүсэх шүдний зуултын гажгийг сонго

- A. Шаамий, орсгой
- B. Зөрмөл
- C. Орсгой, муруй
- D. Зөрмөл, заалхай
- E. Шаамий, муруй

/163./ Үйл зүйн үйлчилгээтэй зэмсэг нь

- A. Винт идэвхжүүлснээр
- B. Резинэн татлаг хийснээр
- C. Төмөр утсыг идэвхжүүлснээр
- D. Булчин агшихад
- E. Уруулын нумыг тэлснээр

/164./ Хоршихуйг хэдэн шүд хоорондоо харьцаж байгааг харгалзан хэрхэн ангилах вэ?

- 1. Шүдний
- 2. Бүлэг шүдний
- 3. Шүдний эгнээний
- 4. Нийт шүдийг хамарсан
- 5. Байнгын зуултын хоршихуй гэж ангилна

/165./ Шүдний хэлбэр бие биенээсээ өөр болж хөгжсөн хөгжлийн хэлбэр

- 1. Гетеродонт
- 2. Олигодонт
- 3. Монодонт
- 4. Гипердонтия
- 5. Гиподонтия

/166./ Эрүүний өнцөг ямар үед багасдаг вэ?

- 1. Сүүн шүд унах
- 2. Сүүн шүд шүдлэх
- 3. Байнгын шүд унах
- 4. Байнгын шүд шүдлэх
- 5. Багасдаггүй

/167./ Зажлах хүч сарниулах замыг хэрхэн ялгах вэ?

- 1. Дух- хамрын
- 2. Шанааны
- 3. Далавч- тагнайн
- 4. Тагнайн
- 5. Хацрын

/168./ Эрүүний үений бүтцэд аль аль нь орох вэ?

1. Толгой
2. Үений уут
3. Үений хонхор
4. Үений жийрэг
5. Үений холбоо

/169./ Орчин үеийн хүний гавлын эзэлхүүн хэд вэ?

1. 100 см.куб
2. 90-100
3. 345
4. 1360
5. 500

/170./ Нүүрний өндрийг хэмжихэд хэрэглэгддэг цэгүүдийг нэрлэнэ үү?

1. gn
2. sn
3. gl
4. Or
5. Go

/171./ Авагддаггүй тулгуурт шүдэлбэрийн сайн тал нь юу вэ?

1. Овор багатай
2. Гүйцэтгэх үйлийн үр нөлөө сайтай
3. Шүдэлбэрт түргэн дасна
4. Бат бөх
5. Цэвэрлэх нь төвөгтэй

/172./ Авагддаг шүдэлбэрийн үндсэн хэсгүүд юу вэ?

1. Суурь
2. Тогтоогч элемент
3. Хиймэл цөгц
4. Араалж хуванцар
5. Нум хуванцар

/173./ Авагддаг шүдэлбэрийн суурийн хэмжээ нь юунаас хамаарах вэ?

1. Унаагүй үлдсэн шүдний тоо
2. Түүшин сэртэнгийн хатингаршлын түвшин
3. Салст бүрхүүлийн зөөлөн чанар
4. Уран тагнайн хүнхэрийн байдал
5. Тагнайд ургацаг байгаа эсэх

/174./ Цутгамал шүдэлбэрийн үндсэн хэсэг юу вэ?

1. Араалж ган
2. Цутгамал нум
3. Тулан тогтоогч дэгээ
4. Хуванцар суурь
5. Тохом хэлбэрт суурь

/175./ Лимфангиомын эмнэл зүйн гол онцлог шинжийг тодорхойлно уу?

- A. Лугших
- B. Үрэвсэх
- C. Шохойжсон эд үүсэх
- D. Тэмтэрхэд эмзэглэх
- E. Гэмтсэн эрхтэн хатингарших

/176./ Тагнайн мэдээгүйжүүлэлт хийхэд баримжаалах бүтэц зүйн хэсгүүдийг нэрлэнэ үү?

1. Дээд 6-р шүдний цөгцийн голын шугам
2. Тагнайн голын заадас
3. Дээд 7-р шүдний цөгцийн голын шугам
4. Дээд агт арааны цөгцийн голын шугам
5. Хүүхэн хэл

/177./ Ухархайн доод мэдээгүйжүүлэлт хийхэд баримжаалах бүтэц зүйн хэсгүүдийг нэрлэнэ үү?

1. Шанаа хоншоорын заадас
2. Хүүхэн хараа
3. Дээд 2-р бага араа
4. Дээд үүдэн шүднүүд
5. Дээд 6-р араа

/178./ Гурамсан мэдрэлийн салаанууд гавлаас гарч ирэх нүхнүүдийг нэрлэнэ үү?

1. Тагнайн нүх
2. Дугуй нүх
3. Оочийн нүх
4. Зуйван нүх
5. Эрүүний нүх

/179./ Булчирхайнаас эдийн шинжилгээ авахад хэрэглэдэг мэдээгүйжүүлэлтийг нэрлэнэ үү?

1. Дамжуулах
2. Угийн
3. Төвгөрийн
4. Нэвчүүлэх
5. Товгорын

/180./ Товгорын мэдээгүйжүүлэлтийн давуу тал юу вэ?

1. Зүү хатгахад бага өвддөг
2. Илүү сайн мэдээ алддаг
3. Мэдээгүйжилт шууд үйлчилдэг
4. Нэг хатгалтаар 3 мэдрэл мэдээгүйждэг
5. Хүндрэл бага тохиолддог

/181./ Вайсблатын мэдээгүйжүүлэлтийн үед гурамсан мэдрэлийн аль салаануудыг дээгүйжүүлж болох вэ?

1. I салаа
2. II салаа
3. I ба II салаа
4. III салаа
5. I ба III салаа

/182./ Шүд авсны дараа хожуу илрэх хэсгийн хүндрэлийг нэрлэнэ үү?

1. Түүшийн хугарал
2. Хожуу цус алдалт
3. Буйл, салст урагдах
4. Оромны үрэвсэл
5. Эрүү хугарах

/183./ Анхны ганхуулах хөдөлгөөнийг уруул руу хийж авдаг шүдийг нэрлэнэ үү?

1. 1.7,1.6
2. 1.1,1.2,1.3
3. 1.6,2.6
4. 3.1,3.2,3.3
5. 3.6,4.6

/184./ Зүүн доод араа шүднүүдийг авах үед эмч өвчтөний аль талд нь зогсох вэ?

1. Зүүн урд
2. Зүүн ард
3. Баруун ард
4. Баруун урд
5. Урд

/185./ Номагийн үед хийгдэх эмчилгээг нэрлэнэ үү?

1. Химийн
2. Өндөр даралтат хүчил төрөгчийн эмчилгээ
3. Тайвшруулах
4. Биеийн эсэргүүцэл сайжруулах

5. Даралт бууруулах
- /186./ ЭНО-ын хатигшлын үед хийгдэх хам эмчилгээг нэрлэнэ үү?
1. Нянгийн эсрэг
 2. Цус солих
 3. Физик эмчилгээ
 4. Тайвшруулах
 5. Туяаны
- /187./ Нүүрний хатигны хэсэг газрын хүндрэлийг нэрлэнэ үү?
1. Идээт менингит
 2. Нүүрний хөх судасны бүлэнт үрэвсэл
 3. Тунгалгийн булчирхайн үрэвсэл
 4. Хоншоорын хөндийн үрэвсэл
 5. Ясны хальсны үрэвсэл
- /188./ 1. Эрүү гурамсан мэдрэлийн аль салаагаар мэдрэлжүүлэгдэх вэ?
- A. I салаа
 - B. II салаа
